






ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ  
2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

# Хүн амьтны хөгжлийн тээвэр

## Боловсрол, бичиг үсгийн мэдлэг



Сэдэвчилсэн судалгаа



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТӨОЛЛОГО**

**БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ**

Улаанбаатар хот  
2011 он

DDC  
370'021'517  
Б-553

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,  
Засгийн газрын III байр  
<http://www.nso.mn>  
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж  
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

ISBN 978-99929-64-67-7

## АГУУЛГА

Сэдэвчилсэн судалгааг бичихэд оролцогчид.....	4
Өмнөх уг.....	9
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН АМЫН ЗҮЙЛ .....</b>	<b>11</b>
1.1. Судалгааны зорилго .....	12
1.2. Ойлголт, тодорхойлолт .....	13
1.3. Судалгааны бүтэц, агуулга.....	20
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮН АМЫН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ.....</b>	<b>21</b>
2.1. Хүн амын боловсролд хамрагдалт .....	22
2.2. Хүн амын сургууль завардалт .....	24
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ.....</b>	<b>27</b>
3.1. Хүн амын боловсролын төвшин .....	28
3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол .....	34
3.3. Боловсрол ба шашин .....	37
3.4. Хүн амын бичиг үсгийн мэдлэг .....	39
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛ .....</b>	<b>41</b>
4.1. Хүн амын ажил эрхлэлт, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг .....	42
4.2. Ажил эрхэлдэггүй хүн амын болон ажилгүйчүүдийн боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг ...	46
4.3 Эдийн засгийн үйл ажиллагааны салбарт ажилладаг хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг .....	50
<b>ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>53</b>
Ашигласан материал .....	57
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>59</b>



## СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГААГ БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### НЭГ. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

**Хинаятын Цоохүү**  
Физикийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

**Цэрэндоржийн Гэлэгжамц**  
Боловсрол судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор

**Чүлтэмиийн Лхагважав**  
Физик математикийн ухааны доктор (Ph.D)

**Миеэжавын Итгэл**  
Боловсрол судлалын ухааны доктор (Ph.D)

**Отгоны Оюунчимэг**  
Цаг уурын магистр

### ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

**Цэндjavын Бадрах**  
Эдийн засагч  
ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

**Жигжидсүрэнгийн Ядамсүрэн**  
Санхүү-Эдийн засагч  
Эдийн засгийн ухааны доктор, профессор

### ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

**Ичинноровын Цэрэндулам**  
Эдийн засагч - Статистикч  
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.1.	Хүн амын суурь боловсролд хамрагдалт.....	24
Хүснэгт 2.2.1.	Сургуульд сурдаггүй 6-15 насны хүүхдийн тоо, аймаг, нийслэл, хувиар, 2010 он.....	25
Хүснэгт 3.1.3.	Арав, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, боловсролын төвшин, аймаг, нийслэл, хувиар, 2010 он .....	34
Хүснэгт 3.2.1.	Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын боловсролын байдлаар, аймаг, нийслэл, хувиар, 2010 он .....	36
Хүснэгт 4.1.1.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын боловсролын төвшин, аймаг нийслэл, хувиар, 2010 он .....	45
Хүснэгт 4.2.1.	Арван тав, түүнээс дээш насны ажилгүйчүүдийн боловсролын төвшин, аймаг, нийслэл, хувиар, 2010 он.....	50

## СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГААНЫ ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.1.	Зургаа /долоо/-гоос хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, хүйс, хувиар, 2000, 2010 он .....	22
Зураг 2.1.2.	Зургаа /долоо/-гоос хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	23
Зураг 2.1.3	Зургаа /долоо/-гоос хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт насын бүлэг, хувиар, 2010 он .....	23
Зураг 2.2.2.	Сургуульд сурдаггүй 6-15 насны хотын хүүхдийн тоо, нас, хүйс, хувиар, 2010 он .....	26
Зураг 2.2.3.	Сургуульд сурдаггүй 6-15 насны хөдөөгийн хүүхдийн тоо, нас, хүйс, хувиар, 2010 он .....	26
Зураг 3.1.1.	Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он .....	28
Зураг 3.1.2.	Арав, түүнээс дээш насны хотын хүн амын боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он .....	29
Зураг 3.1.3.	Арав, түүнээс дээш насны хөдөөгийн хүн амын боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он ...	30
Зураг 3.1.4.	Арав, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он ....	31
Зураг 3.1.5.	Арав, түүнээс дээш насны эмэгтэй хүн амын боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он....	31
Зураг 3.1.6.	Арав, түүнээс дээш настай хүн амын боловсролын төвшин, улс, хот, хөдөө, хувиар, 2010 он ..	32
Зураг 3.1.7.	Арав, түүнээс дээш настай хүн амын боловсролын төвшин, эрэгтэй, эмэгтэй, хувиар, 2010 он ...	33
Зураг 3.2.1.	Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, хүйс, хувиар, 2010 он .....	35
Зураг 3.3.1.	Боловсролтой хүн амд шашинтны эзлэх хувь, 2010 он .....	37
Зураг 3.3.2.	Боловсролтой хүн амд шашинтны эзлэх хувь, хүйсээр, 2010 он .....	38
Зураг 3.4.1.	Хүн амын бичиг үсгийн мэдлэг, он, хувиар .....	39
Зураг 3.4.4.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг, аймаг, нийслэл, хувиар, 2010 он	40
Зураг 4.1.1.	Арван тав, түүнээс дээш настай ажил эрхэлдэг хүн амын боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он .....	43
Зураг 4.1.2.	Арван тав, түүнээс дээш настай ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он .....	43
Зураг 4.1.3.	Арван тав, түүнээс дээш настай ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он .....	44
Зураг 4.1.4.	Арван тав, түүнээс дээш насны боловсролгүй ажил эрхэлдэг хүн амын бичиг үсгийн мэдлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он .....	44
Зураг 4.2.1.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй, боловсролгүй хүн амын бичиг үсгийн мэдлэг, хувиар, 2000, 2010 он.....	47
Зураг 4.2.2.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн амын боловсролын төвшин, хувиар, 2000, 2010 он .....	47
Зураг 4.2.3.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн амын боловсролын төвшин, хүйс, хувиар, 2000, 2010 он .....	48
Зураг 4.2.4.	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй боловсролгүй хүн амын бичиг үсгийн мэдлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он.....	49
Зураг 4.3.1.	Ажил эрхэлдэг хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хувиар, 2000, 2010 он .....	51



## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.1. Боловсролтой хүн амын тоо, 1963-2010 он /улсын дун/ .....	60
Хүснэгт 2.1.2. Боловсролтой хүн амын тоо, 1963-2010 он /эрэгтэй/.....	60
Хүснэгт 2.1.3. Боловсролтой хүн амын тоо, 1963-2010 он /эмэгтэй/ .....	60
Хүснэгт 2.1.4. Хотын боловсролтой хүн амын тоо, 1963-2010 он.....	60
Хүснэгт 2.1.5. Хөдөөгийн боловсролтой хүн амын тоо, 1963-2010 он .....	61
Хүснэгт 2.1.6. Хоёроос хорин есөн насны сургуульд сурдаг /цэцэрлэгт хүмүүждэг/ хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он .....	61
Хүснэгт 2.1.7. Хоёроос хорин есөн насны хотын сургуульд сурдаг /цэцэрлэгт хүмүүждэг/ хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он .....	61
Хүснэгт 2.1.8. Хоёроос хорин есөн насны хөдөөгийн сургуульд сурдаг /цэцэрлэгт хүмүүждэг/ хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....	62
Хүснэгт 2.2.1. Сургуульд сурдаггүй 6-15 насны хүүхдийн тоо, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2010 он.....	62
Хүснэгт 2.2.2. Сургуульд сурдаггүй 6-15 насны эрэгтэй хүүхдийн тоо, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2010 он .....	63
Хүснэгт 2.2.3. Сургуульд сурдаггүй 6-15 насны эмэгтэй хүүхдийн тоо, улс, аймаг, нийслэл, насны бүлгээр, 2010 он .....	63
Хүснэгт 3.1.1. Арав, түүнээс дээш настай хүн амын тоо, насны бүлэг, боловсролын төвшингөөр, 2010 он.....	64
Хүснэгт 3.2.1. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй суурин хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он .....	64
Хүснэгт 3.2.2. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй суурин хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он, эрэгтэй .....	65
Хүснэгт 3.2.3. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй суурин хүн амын тоо, насны бүлэг, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он .....	65
Хүснэгт 3.2.4. Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, аймаг, нийслэл, боловсролын төвшингөөр, 2010 он .....	66
Хүснэгт 3.3.1. Арван тав, түүнээс дээш насны шашиантан, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, шашины төрлөөр, 2010 он .....	67
Хүснэгт 3.3.2. Арван тав, түүнээс дээш насны эрэгтэй шашиантан, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, шашины төрлөөр, 2010 он .....	68
Хүснэгт 3.3.3. Арван тав, түүнээс дээш насны эмэгтэй шашиантан, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, шашины төрлөөр, 2010 он .....	69
Хүснэгт 3.4.1. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он .....	70
Хүснэгт 3.4.2. Арав, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он .....	70
Хүснэгт 3.4.3. Арав, түүнээс дээш насны эмэгтэй хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он .....	71
Хүснэгт 3.4.4. Арав, түүнээс дээш насны хотын хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он .....	71
Хүснэгт 3.4.5. Арав, түүнээс дээш насны хөдөөгийн хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, насны бүлгээр, 2010 он .....	72
Хүснэгт 3.4.6. Арав, түүнээс дээш насны суурин хүн амын тоо, боловсролын төвшин, аймаг, нийслэлээр, 2010 он .....	73
Хүснэгт 3.4.7. Арван тав түүнээс дээш насны хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэг, аймаг, нийслэлээр, 2010 он .....	74
Хүснэгт 4.1.1. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг суурин хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он.....	75
Хүснэгт 4.1.2. Арван тав, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он .....	76
Хүснэгт 4.1.4. Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын боловсролын төвшин, аймаг, нийслэлээр, 2010 он .....	77
Хүснэгт 4.1.3. Арван тав, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он .....	78

Хүснэгт 4.3.1. Арван тав, түнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он .....	79
Хүснэгт 4.3.2. Арван тав, түнээс дээш насны ажил эрхэлдэг эрэгтэй хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он, .....	80
Хүснэгт 4.3.3. Арван тав, түнээс дээш насны ажил эрхэлдэг эмэгтэй хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он.....	81
Хүснэгт 4.3.4. Арван тав, түнээс дээш насны ажил эрхэлдэг хотын хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он.....	82
Хүснэгт 4.3.5. Арван тав, түнээс дээш насны ажил эрхэлдэг хөдөөгийн хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он.....	83



## ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын төр засгаас ард иргэдийнхээ боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн талаарх тоо баримтыг 70 орчим жилийн өмнөөс цуглувуж ирсэн баялаг туршлагатай юм. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дунд үндэслэн “Хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэг” сэдэвчилсэн судалгаа хийсэн нь хүүхэд, залуучуудын сургуульд хамрагдалт, завсардалт, хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын төвшинг хүн амын нас, хүйс, байршилаар тодорхойлж, эдгээр үзүүлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлийг тус улсын нийгэм, эдийн засгийн сүүлчийн 30 орчим жилд гарсан зарим өөрчлөлттэй уялдуулан үндэсний болон аймаг, нийслэлийн төвшинд тодорхойлжээ.

Монгол Улс мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц бодлогодоо “Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын төвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ...”<sup>1</sup> хэмээн заасан байдаг. ХХI-р зуунд Монгол улсын хүн амын боловсролын чанарыг дээшлүүлэх, бүх төвшний боловсролыг дотооддоо төдийгүй, гадаадад хөрвөх чадвартай болгох талаарх төр, засгийн бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгох, суралцагчид, иргэнд боловсролын үйлчилгээний талаар бодитой мэдээллийг хүргэхэд энэхүү сэдэвчилсэн судалгаа ихээхэн ач холбогдолтой болжээ. Мөн түүнчлэн боловсролд зарцуулсан хөрөнгийн үр дүнг тооцох, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, манай улсын боловсролын тогтолцоо, агуулга, стандарт, удирдлага, зохион байгуулалтыг төгөлдөржүүлэн хөгжүүлэх талаар бодлого боловсруулагчид, судлаачид, олон нийтэд шаардлагатай мэдээллийг хүргэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,  
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН  
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

 С.МЭНДСАЙХАН

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод сууринсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Улаанбаатар, 2008 он, 22 дахь тал



# НЭГЛҮГЭЭР БУЛЭГ

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ





## 1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Боловсрол бол нийгмийн оюуны амьдрал, улс үндэстний иргэншлийн гол үзүүлэлт, нийгмийн хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл мөн. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт: “бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын төвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ” гэж заасан бол Боловсролын салбарыг 2021 он хүртэл хэрэгжүүлэх “БОЛОВСРОЛ” үндэсний хөтөлбөрт боловсролын шинэчлэлийн онцлогийг: “бүх шатны боловсролын тогтолцоог нийгмийн шинэ шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжлийг нь хангах, боловсролын үйлчилгээний хүртээмжид баримжаалсан бодлогоос чанар, үр өгөөжийг нь дээшлүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын төвшинд ойртуулан төгөлдөржүүлэх бодлогод шилжих” гэж тодорхойлсон байна.

Эдгээр баримт бичигт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх, ХХI-р зуунд Монгол улсын хүн амын боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, бүх төвшний боловсролыг дотооддоо төдийгүй, гадаадад хөрвөх чадвартай болгоход төр, засгийн бодлого боловсруулах, боловсролын төлөвлөлт /мэргэжлийн чиглэл, элсэлтийн тоо, хүйсийн харьцаа, хөрөнгө оруулалт, хүний нөөц зэрэг/-ийг боловсронгуй болгох, суралцагчид, иргэнд боловсролын үйлчилгээний талаар бодитой мэдээллийг хүргэхэд энэхүү сэдэвчилсэн судалгааны ажлын зорилго оршиж байгаа билээ. Түүнчлэн энэхүү судалгаанд Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнд тулгуурлан хүүхэд, залуучуудын сургуульд хамрагдалт, завсардалт, хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловролын төвшин, хөдөлмөр эрхлэлт, сургуулийн өмнөх боловсрол, боловсрол ба шашин шүтлэгийн хамаарал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол зэрэг үзүүлэлтийг хүн амын нас, хүйс, байршилаар өөрчлөлтийг нь тодорхойлж, эдгээр үзүүлэлтэд нөлөөлсөн хүчин зүйлийг тус улсын нийгэм, эдийн засгийн сүүлийн 30 орчим жилд гарсан зарим өөрчлөлттэй уялдуулан үндэсний болон аймаг, нийслэлийн төвшинд тодорхойлох зорилго тавьсан юм. Энэ нь боловсролд зарцуулсан хөрөнгийн үр дүнг тооцох, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, манай улсын боловсролын тогтолцоо, агуулга, стандарт, удирдлага, зохион байгуулалтыг төгөлдөржүүлэн хөгжүүлэх талаар бодлого боловсруулагчид, судлаачид, олон нийтэд шаардлагатай мэдээллийг хүргэхэд зориулагдсан юм.

Энэхүү 2 дахь удаагийн сэдэвчилсэн судалгааны онцлог нь нэгд, зөвхөн 2000, 2010 оны төдийгүй өмнөх хэд хэдэн удаагийн хүн амын тооллогын материалыг ашиглан боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн бодит болон харьцангуй утгаар тодорхойлсон; хоёрт, 2000 оны сэдэвчилсэн судалгаанд тусгагдаагүй боловсрол ба шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол зэрэг асуудлыг шинээр тусгаж өгсөнд оршино.

## 1.2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

### ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
ӨРХ, ХҮН АМ		
1.	<b>Өрх</b>	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.
2.	<b>Үндсэн өрх</b>	“Үндсэн өрх” гэж сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
3.	<b>Хамт суудаг өрх</b>	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
4.	<b>Өрхийн тэргүүлэгч</b>	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-аас дээш настай, өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
5.	<b>Өрхийн ам бүлийн гишүүд</b>	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тоолох үед тухайн өрх айлд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД		
6.	<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүн</b>	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ.
7.	<b>Төрөлхийн</b>	Удамшилын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
8.	<b>Олдмол</b>	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
9.	<b>Харааны</b>	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
10.	<b>Сонсголын</b>	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааний чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
11.	<b>Хэл ярианы</b>	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
12.	<b>Хөдөлгөөний</b>	Биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
13.	<b>Сэтгэцийн</b>	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх, ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд бие авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцооны дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.



### СҮҮРЬШИЛ

- |                   |   |
|-------------------|---|
| 14. Байнга суудаг | Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн                               |
| 15. Түр эзгүй     | Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааныхаа нэгжээс гадагш 6 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн                              |
| 16. Түр суугаа    | Тооллогын товоос өмнө өөр засаг захиргааны нэгжээс ирж, тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн |

### БОЛОВСРОЛ

- |  |  |
|--|--|
| 17. Боловсролгүй                         | ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөөгүй бол <b>Боловсролгүй</b> хүн гэнэ. Мөн 2010 онд ЕБС-ын 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг <b>Боловсролгүй</b> гэж үзнэ.   |
| 18. Бага боловсрол                       | ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөн, мөн албан бус боловсролын дүйцэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн   |
| 19. Бүрэн бус дунд (суурь) боловсрол     | ЕБС-ийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл), 8 дугаар ангийг (1975-2004 оныг дуустал), 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн   |
| 20. Бүрэн дунд боловсрол                 | ЕБС-ийн 10 дугаар ангийг (2006 он дуустал), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын атtestат ба үнэмлэхтэй хүн   |
| 21. Техникийн болон мэргэжлийн боловсрол | MCYT (хуучнаар ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн   |
| 22. Тусгай мэргэжлийн дунд боловсрол     | Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн  |
| 23. Дээд боловсрол                       | Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг <b>Дээд боловсролтой</b> гэж үзнэ. Түүнчлэн, Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахини хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг мөн энэ ангилалд хамааруулна. |
| 24. Бичиг үсэг мэддэг                    | Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичих чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг <b>Бичиг үсэг мэддэг</b> гэж үзнэ.   |
| 25. Бичиг үсэг мэддэггүй                 | Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичих чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг <b>Бичиг үсэг мэддэггүй</b> гэж үзнэ.  |

### ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

- |                   |   |
|-------------------|---|
| 26. Огт гэрлээгүй | Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн                        |
| 27. Батлуулсан    | Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн |

28. <b>Батлуулаагүй</b>	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр булийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
29. <b>Цуцалсан</b>	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацааг харгалзахгүйгээр <b>Цуцалсан</b> гэж үзнэ.
30. <b>Тусгаарласан</b>	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр <b>Тусгаарласан</b> гэж үзнэ.
31. <b>Бэлбэсэн</b>	Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг <b>Бэлбэсэн</b> гэж үзнэ .

### АЖИЛ ЭРХЛЭЛТ

32. <b>Ажил эрхэлдэг хүн</b>	Тооллогын товын үед тогтмол ажил эрхэлж байгаа, эсвэл тогтмол ажил эрхэлдэггүй боловч товын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалинтай ажил эрхэлсэн хүн
33. <b>Ажилгүй хүн</b>	Хөдөлмөр хalamж, үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсвэл бүртгүүлээгүй, тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүн

### МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА ТОДОРХОЙЛОЛТ

34. <b>Менежер</b>	Менежер нь Засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтанг хамруулна. Тухайлбал, төрийн болон хувийн аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын бүх төвшний дарга, захирал, хууль тогтоогч, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, бүх төвшний засаг дарга, захирагч, ТББ-ын удирдах албан тушаалтан, менежер гэх мэт.
35. <b>Мэргэжилтэн</b>	Мэргэжтэн нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, тэдгээрийг системтэйгээр заах сургах буюу мэргэжлийн өндөр төвшин шаардсан ажил гүйцэтгэгч байна. Тухайлбал, шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн, эмч, сувилагч, багш, судлаач, бизнесийн болон захиргааны мэргэжилтэн, программ зохиогч, шашны мэргэжилтэн, уран бүтээлч, дуучин, жүжигчин гэх мэт.
36. <b>Техник боловон туслах/дэд мэргэжилтэн</b>	Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн нь шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ. Тэд уул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн арга ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулна. Физик, инженерийн ухааны технич, уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч, технологи процесс, чанар шалгагч, амьд ертөнц судлах ухааны технич, холбогдо бусад туслах/дэд мэргэжилтэн, усан онгоц, агаарын хөлгийн хянач, технич гэх мэт.
37. <b>Контор, үйлчилгээний ажилтан</b>	Тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах ба мөнгөний гүйлгээ хийх, аялал жуулчлал зохион байгуулах, мэдээлэл авах, хүсэлт тавих, уулзалт товлох зэрэг туслах шинжтэй олон төрлийн үүргийг гүйцэтгэнэ. Компьютерийн операторч, үйлчилгээний туслах ажилтан, тооцоолол, материал, тоо бүртгэлийн ажилтан, конторын бусад туслах ажилтан гэх мэт.
38. <b>Худалдаа, үйлчилгээний ажилтан</b>	Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах юмуу хууль бус үйлдэл, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, муҳланаар бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Хувийн үйлчилгээний ажилтан, худалдааны ажилтан, хувь хүн асрах ажилтан, хамгаалах үйлчилгээний ажилтан гэх мэт.



39. Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр булийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж, үржүүлнэ. Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан, өрхийн хэрэгцээний шинжтэй фермэрч, загасчин, анчин болон түүн цуглувлагч гэх мэт.
40. Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металлд хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин, механизмын тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэл салбарт мэдлэг, ур чадвараа хэрэглэнэ. Металл, машин, механизмын түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан, гар урлал, хэвлэлийн ажилтан, цахилгаан болон цахим техники, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч гэх мэт.
41. Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	Хөдөө аж ахуйн машин, механизмын тоног төхөөрөмжийг биечлэн жолоодох эсвэл зайнаас буюу алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах, галт тэрэг, хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин, механизмын тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, эд анги, хэсгүүдээс бүрдсэн бүтээгдэхүүнийг заавар, журам, стандарт, шаардлагын дагуу угсралт ажил эрхэлнэ. Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, жолооч, хөдөлгөөнт төхөөрөгийн операторч гэх мэт.
42. Энгийн ажил, мэргэжил	Энгийн ажил эрхлэгч нь өдөр тутмын, байнга давтагдаа шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ. Цэвэрлэгч, туслагч, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил, хүнс бэлтгэлийн туслах ажил, гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил, бусад энгийн ажил гэх мэт.
43. Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Зэвсэгт хүчний офицерийн цол бүхий Монгол Улсын Зэвсэгт хүчний зохих албан тушаалд цэргийн алба хаахыг офицерийн алба гэнэ. Зэвсэгт хүчний офицер нь төрөл бүрийн энгийн ажил, мэргэжилд байдаг ижил төстэй үүрэг гүйцэтгэж болно. Энэ бүлэгт Зэвсэгт хүчинд алба хааж байгаа дунд офицер, ахлах офицер, дээд офицерийн нийт бие бүрэлдэхүүн багтана.

#### **ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

44. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Мал, амьтны болон таримал, байгалийн ургамлын нөөцийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа орно. Үүнд: газар тариалан эрхлэх, мал, амьтныг өсгөх, үржүүлэх, түүний ашиг шимиийг авах; загас барих; ан агнуур; ойжуулалт, мод бэлтгэл; фермерийн аж ахуйн үйл ажиллагаа зэрэг хамаарна.
45. Уул уурхай, олборлолт	Байгалийн хатуу (нүүрс, хүдэр), шингэн (нефть) эсвэл хий (байгалийн хий) зэрэг эрдэс баялагийг олборлох уул уурхайн үйл ажиллагаа багтана. Олборлох үйл ажиллагаа нь далд эсвэл ил уурхай, далайн ёроолын уурхай гэх мэт уурхайгаас төрөл бүрийн аргаар гаргаж авах үйл ажиллагаа байж болно.
46. Боловсруулах үйлдвэрлэл	Боловсруулах үйлдвэрлэл нь түүхий эд, материалыг физик болон химийн аргаар хувиргаж шинэ бүтээгдэхүүн үүсгэх үйл ажиллагаа юм. Боловсруулах үйлдвэрлэлийн завсрлын бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүнүүд орно. Мөн бусад боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох түүхий эд материалын бодис эсвэл бүтээгдэхүүнийг хувиргахад орох түүхий эд байна. Барааг шинэчлэх, сэргээн босгох, өөрчлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа байна.

47. Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Энэ салбарт дэд бүтцийн /сүлжээ/ шугам хоолойгоор дамжуулан цахилгаан эрчим хүч, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах үйл ажиллагаа хамрагдана. Түүнчлэн, нэгдсэн сүлжээгүй орон нутгийн чанартай барилга байгууламжийн бие даасан эх үүсвэр бүхий цахилгаан, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах, түгээх ажиллагаа мөн багтана.
48. Ус хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	Энэ салбарт өрхийн болон үйлдвэрийн хатуу эсвэл хатуу бус, бохирдсон талбай зэргийн хог, хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулах явцтай холбоотой үйл ажиллагаа багтана. Хог хаягдал, бохир ус боловсруулах үйл ажиллагааны үр дүнд ариутгасан эсвэл шинэ бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагаа байж болно. Усан хангамжийн үйл ажиллагаа нэгтгэгдэн энэ салбарт орно. Ус хангамжийн үйл ажиллагаа ихэнхдээ бохир усыг цэвэрлэх, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой байдаг ба аж ахуйн нэгжүүд эдгээр үйл ажиллагааг хамтруулан хийдэг байж болно.
49. Барилга	Их барилга угсралт болон иргэний инженерийн байгууламж, байшин, барилгыг угсрах болон мэргэжсэн барилгын үйл ажиллагаа энэ салбарт багтана. Энд шинэ ажил, барилга засвар, нэмэлт болон жижиг засвар, угсармал барилга, барилгын талбай, түр зуурын чанартай барилга угсрах үйл ажиллагаа орно.
50. Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, тухайлбал хувирган өөрчлөхгүй худалдаалах, барааг худалдан авах явцад гарах үйлчилгээ мөн машин, мотоциклийн засвар, үйлчилгээ хамаарна.
51. Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Хий дамжуулах хоолой, төмөр зам, авто зам, усан ба агаарын тээврийн тогтсон хуваарьтай, хуваарьгүй ачаа ба зорчигч тээврлэлт, агуулах, ачаа, тээшийн үйлчилгээ, автомашины зогсоол, гарааш зэрэг үйл ажиллагаа орно. Түүнчлэн, тээврийн хэрэгслийг ажиллуулагч хүнтэй нь түрээслэх үйл ажиллагаа энэ салбарт багтана. Мөн шуудан, холбооны үйл ажиллагаа орно.
52. Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Түр зуурын зочин, бусад аялагчдыг богино хугацаагаар байр сууцаар хангах, шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа орно. Энэ салбарт тусгагдаж байгаа нэмэгдэл үйлчилгээний хэмжээ, төрөл нь нэлээд их байна.
53. Мэдээлэл, холбоо	Энэ салбарт мэдээлэл, соёлын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт, энэ төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа, тухайлбал холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах болон мэдээллийн үйлчилгээтэй холбоотой бусад үйл ажиллагаа орно.
54. Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Даатгалын үйл ажиллагаа, давхар даатгал болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, мөн санхүүгийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагааг оруулан санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа энэ салбарт орно. Холдинг компани, траст, сан болон санхүүгийн бусад үйл ажиллагаа зэрэг холдинг хөрөнгийн үйл ажиллагаа энэ салбарт багтана.
55. Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Энд лизингийн үйлчилгээ олгогчид, агентууд, брокеруудын үл хөдлөх хөрөнгө арилжаалах, үл хөдлөх хөрөнгө түрээслэх, үнэлгээ хийх зэрэг үл хөдлөх хөрөнгийн бусад үйлчилгээ орно. Энэ салбарын үйл ажиллагаа нь төлбөр, гэрээний үндсэн дээр хийгдэж эзэмшигчийн эсвэл лизингээр авсан өмчийг ашиглах үйл ажиллагаа байж болно. Мөн энд эзэмшигчийн эсвэл лизингийн баригдаж байгаа барилга болон барилга, байгууламжийг оруулна. Энэ салбарт үл хөдлөх хөрөнгийн менежерийн үйл ажиллагаа багтана.
56. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Мэргэшсэн мэргэжил, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа энэ салбарт орно. Эдгээр үйл ажиллагаа нь өндөр төвшний сургалт, мэргэшсэн мэдлэг олгох, хэрэглэгчдэд ур чадвар олгох зэрэг байна.



57. Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Ерөнхий бизнесийн үйл ажиллагааг дэмжих төрөл бүрийн үйл ажиллагааг энд хамруулна.
58. Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Төрийн удирдлагаар хэрэгждэг үйл ажиллагаа орно. Үүнд хуулийн тайлбар, тогтоол ба тэдгээрийн зохицуулалт, тэдгээр дээр сууринсан үйл ажиллагаануудын удирдлага, хууль тогтоох үйл ажиллагаа, татвар, улсын батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа, цагаачалын үйлчилгээ, гадаад харилцааны үйл ажиллагаа ба засгийн газрын хөтөлбөрүүдийн удирдлагын үйл ажиллагаа зэрэг орно. Мөн энэ салбарт албан журмын нийгмийн хамгааллын үйл ажиллагаа багтана.
59. Боловсрол	Энэ салбарт бүх шатны, бүх мэргэжлийн боловсролыг өдөр, орой, эгнээ хэлбэрээр анги, танхим, радио, телевиз болон бусад мэдээллийн хэрэгсэл, зайн сургалтаар дамжуулан олгосон боловсролын үйл ажиллагаа орно. Төрөл бүрийн сургалтын байгууллагын албан болон албан бус сургалт багтана. Түүнчлэн, насанд хүрэгчдийн боловсрол, бичиг үсэг тайлгадалтын хөтөлбөр зэрэг орно. Мөн бүх насны цэргийн сургууль, академи, хориыхын сургууль хамрагдана.
60. Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Энэ салбарт эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа орно. Үйл ажиллагаанд нь эмнэлгийн анагаахын мэргэжилтнүүдэд эмнэлг болон бусад сургалтын сургагдсан эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанаас эхлэн хүн амыг асрах үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээ болон заавал мэргэжлийн эмнэлгийн ажилтан бус нийгмийн ажилтны үйл ажиллагаа багтана.
61. Үрлаг, үзвэр, тоглоом наадам	Энэ дэд салбарт өргөн цар хүрээг хамарсан төрөл бүрийн соёлын уулзалт, үзвэр болон олон нийтийг хамарсан сонирхолтой тоглоом наадам багтахын зэрэгцээ амьд үзүүлбэр, музейн үйлчилгээ, мөрийтэй спорт, амралт зугааллыг үйл ажиллагаа хамрагдана.
62. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Энэ салбарт байгууллагуудын гишүүнчлэлтэй холбоотой үйл ажиллагаа, компьютерын болон хувь хүн, өрхийн хэрэглээний барааны засвар үйлчилгээ орох бөгөөд өмнөх, бүлэг, ангид ороогүй хувь хүнтэй холбоотой төрөл бүрийн бусад үйлчилгээний үйл ажиллагаа орно.
63. Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; Өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	Гэрийн үйлчлэгч, тогооч, зөөгч, цэвэрлэгч, барлаг, шивэгчин, угаагч, цэцэрлэгч, манаач, малчин, ногочин, байнгын харгалзагч, жолооч, хаалгач, гэрийн хүмүүжүүлэгч, хүүхэд асрагч, гэрийн багш, нарийн бичиг зэрэг ажил, үйлчилгээг айл, өрхөд цалин хөлстэйгээр хийх үйл ажиллагаа орно. Энд зөвхөн өөрийн хэрэглээ, амь зуулгандаа зориулан, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй хэд хэдэн төрлийн бараа болон үйлчилгээ явуулдаг өрх хамрагдана.
64. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	Энэ ангид Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн төрөлжсөн байгууллагууд, бус нутгийн төлөөлөгчид, Олон улсын валютын сан, Дэлхийн Банк, Дэлхийн гаалийн байгууллага, Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Нефть экспортлогч орнуудын байгууллага, Европын холбоо, Европын худалдааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагын үйл ажиллагаа орно. Тухайн улс оронд байрлаж буй дипломат болон консулын төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь аль улсыг төлөөлж байгаагаас үл хамааран энэ ангид мөн багтана.

## ОРОН СУУЦ

65. Орон сууцны байшин	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна.
66. Бие даасан тохилог сууц	Бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.
67. Сууцны тусдаа байшин	Гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын усан систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.
68. Оюутан сургачдын нийтийн байр	Бүх шатны сургуулиудийн оюутан, сургачдын хамтран амьдрахад зориулагдсан байр
69. Ажиллагчдын нийтийн байр	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид нийтээр амьдрахад зориулсан байр
70. Нийтийн зориулалтын бусад байр	Амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, шорон, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байр
71. Өрөөний тоо	Нийт өрөөний тоонд унтлагын өрөө, амрах болон ажлын өрөө орно.
72. Сууцны талбай (кв.метр)	Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай /амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын болон хооллох өрөө/ туслах өрөө, тасалгаа /гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах/-ны талбайн нийлбэр

## БОЛОВСРОЛТОЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ОНЦЛОГ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

1. "Боловсролын төвшин" гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг хэлнэ. Монгол Улсын боловсролыг төвшингээр нь сургуулийн өмнөх боловсрол, Бага боловсрол, дунд боловсрол, дээд боловсрол гэж ангилдаг. Дунд боловсрол нь суурь, бүрэн дунд боловсрол, дээд боловсрол нь дипломын, бакалаврын, магистрын, докторын гэсэн зэрэглэл /шатлал/-тэй байна. Бүрэн дунд боловсролд тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, техникийн болон мэргэжлийн дунд /хуучнаар техник мэргэжлийн/ боловсролыг хамруулдаг.

2. "Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн төвшин" -ийг тодорхойлохдоо бага, дунд, дээд боловсролтой болон бичиг үсэг мэддэг насанд хүрэгчдийн тооны нийлбэрийг тухайн насны хүн амын тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ. Энэхүү хувийг 100-д хуваан тоогоор илэрхийлснийг "Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын амжилт /тайлагдалт/-ын индекс" гэнэ.

3. "Сургуульд хамран сургалтын хувь"-ийг тодорхойлохдоо бага, дунд, дээд боловсрол олгодог бүх шатны сургуульд суралцаж байгаа суралцагчдын тоог сургуулийн насны хүн амын тоонд хувааж, хувиар илэрхийлнэ. Хүүхдийн сургуульд элсэх наснаас хамаарч 2000 оныг хүртэл 8-22 насны, 2010 оноос 6-22 насны хүн амыг хамруулж энэхүү үзүүлэлтийг тооцож байна. Харин "Сургуульд хамран сургалтын индекс"-ийг тодорхойлохдоо сургуульд хамрагдагсдын хувийг 100-д хувааж тоогоор илэрхийлнэ.

4. Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жинг: Бүх хэв шинжийн ЕБС-д суралцаж байгаа 8-15 /2004 он хүртэл/, 7-15 /2005-2007 он/, 6-15 / 2008 оноос/ насны хүүхдийн тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ. Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жинг 100-д хувааж тоогоор илэрхийлснийг Суурь боловсролын хамран сургалтын индекс гэнэ.



### 1.3. СУДАЛГААНЫ БҮТЭЦ, АГУУЛГА

“Хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэг” сэдэвчилсэн судалгаа нь 4 бүлэг, 15 зүйл, ашигласан материал, зураг хүснэгтийн жагсаалт, хавсралт гэсэн бүтэцтэй болно. Нэгдүгээр бүлэгт судалгааны зорилго, онцлог, судалгаанд хэрэглэсэн ойлголт тодорхойлолт. Хоёрдугаар бүлэгт хүн амын боловсролд хамрагдах байдлыг авч үзсэн бөгөөд энэхүү асуудлын хүрээнд хүн амын сургууль, цэцэрлэгт хамрагдах байдал, сургууль завсардалт. Гуравдугаар бүлэгт хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролыг нас, хүйс, байршил /аймаг, нийслэл, хот, хөдөө/-аар нь судалснаас гадна хүн амын боловсрол, шашин шүтлэгийг хамруулав. Боловсролын төвшинг олон улсын нийтлэг жишгийн дагуу бага, суурь /бүрэн бус дунд/, бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн дунд, тусгай мэргэжлийн дунд болон бүрэн бус дээд, дээд /дипломын, бакалаврын, магистрын, докторын гэсэн зэрэглэлтэй/ гэж ангилан хүн амын боловсролын төвшинг 2010, 2000 оноор, нас, хүйс, хот, хөдөө, аймаг, нийслэлээр харьцуулан судлав. Дөрөвдүгээр бүлэгт 15, түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлт, боловсролын байдлыг харьцуулан судлахдаа нас, хүйс, байршил /хот, хөдөө, аймаг, нийслэл/-аар, мөн ажилгүйчүүдийн боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг, эдийн засгийн үйл ажиллагааны салбарт ажил эрхэлдэг хүн амын боловсролын төвшинг нас, хүйсээр харьцуулан судалсан юм.

Сэдэвчилсэн судалгаанд үзүүлэлтүүдийг дэлгэрүүлж хүснэгтээр хавсаргав.

# ХОЁРЛУГААР БҮЛЭГ

## ХҮН АМЫН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ




## 2.1. ХҮН АМЫН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ

Монгол Улсын Их Хурлаас 1991 онд боловсролын тухай хууль, 1995 онд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого болон боловсролын тухай хууль, бага, дунд боловсролын тухай, дээд боловсролын тухай хууль /багц хууль/-ийг тус тус баталж мөрдүүлснээс гадна эдгээр хуульд 1998, 2000, 2002, 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ. 2002 онд мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2006 онд сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг тус тус шинээр батлан мөрдүүлэв. Хүн амын сурч боловсрох эрх зүйн зохицуулалтыг зохих төвшинд бий болгосон нь хүн амын боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр манай улсын 7-29 насны хүн амын 47.8 хувь, үүнээс эрэгтэйчүүдийн 44.5 хувь, эмэгтэйчүүдийн 51.1 хувь нь ямар нэг төвшний боловсрол олгодог сургуульд суралцаж байсан (11, хуудас 12, Хавсралт хүснэгт 2.1.6) бол 2010 онд 6-29 насны хүн амын 58.1 хувь нь, үүнээс эрэгтэйчүүдийн 55.7 хувь, эмэгтэйчүүдийн 60.6 хувь нь ямар нэг төвшний боловсрол олгодог сургуульд суралцаж байна (Зураг 2.1.1, Хавсралт хүснэгт 2.1.6).


Үүнээс үзэхэд сүүлийн 10 жилд энэ насны хүн амын сургуульд хамрагдалт 10.3 пунктээр, үүний дотор эрэгтэйчүүд 11.2, эмэгтэйчүүд 9.5 пунктээр тус тус төссөн байна. Түүнчлэн 2010 онд 2-5 насны хүүхдийн 60 хувь, үүнээс эрэгтэйн 59.1, эмэгтэйн 61.1 хувь нь цэцэрлэгт буюу сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.

**ЗУРАГ 2.1.1. ЗУРГАА /ДОЛОО-/ГООС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН**




Сургуульд хамрагдалтыг байршилаар нь үзвэл 2010 онд 6-29 насны хотын хүн амын сургуульд хамрагдалт 60.1 хувь, үүнээс эмэгтэй 61.8 хувь, эрэгтэй 58.4 хувь (Зураг 2.1.2, Хавсралт хүснэгт 2.1.7), хөдөөгийн хүн амын сургуульд хамрагдалт 53.8 хувь, үүнээс эрэгтэй 50.2, эмэгтэй 57.8 хувь (Хавсралт хүснэгт 2.1.8) тус тус байна. Сургуульд хамрагдалт хотод хөдөөгөөс 4.0 хувь, үүний дотор хүйсийн хувьд эрэгтэй нь эмэгтэйгээс хотод 6.3 хувь, хөдөөд 8.2 хувиар тус тус илүү байна.

**ЗУРАГ 2.1.2. ЗУРГАА /ДОЛОО/-ГООС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**



Хүн амын сургуульд хамрагдалтыг насны ангиллаар үзвэл 6-12 насанд 97.3 хувь, 13-15 насанд 94.5 хувь, 16-18 насанд 81.7 хувь, 19-23 насанд 39.7 хувь, 24-29 насанд 6.4 хувь тус тус байна.

**ЗУРАГ 2.1.3 ЗУРГАА /ДОЛОО/-ГООС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2010 ОН**



Боловсролын тухай хуульд заасны дагуу “Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших” үүрэгтэй тул иргэдийн суурь боловсролын хамран сургалтын байдлыг сүүлийн 30 жилээр авч үзэхэд 8-15, 6-15 насны хүн амын суурь боловсролд хамрагдалтын хувийн жин 1990 онд 93.5 хувь, үүний дотор эмэгтэйнх 97.4, эрэгтэйнх 89.6 хувь байсан бол 2000 онд эдгээр үзүүлэлт харгалзан 80.6 хувь, 83.6 хувь, 77.5 хувь болж 10 гаруй пунктаар буурсан байна. Гэвч энэ байдал богино хугацаанд өөрчлөгдж, 2010 онд 6-15 насны хүн

амын суурь боловсролд хамрагдалтын хувийн жин 96.4 хувь, үүний дотор эмэгтэйнх 94.5 хувь, эрэгтэйнх 98.4 хувь болж тус тус өссөн байна (Хүснэгт 2.1.1). Хүн амын суурь буюу бүрэн бус дунд боловсролд хамрагдалтад гарсан энэхүү түр зуурын өөрчлөлт нь зах зээлийн эдийн засгийн харилцааны тухайн үеийн онцлогтой холбоотой юм.

### ХҮСНЭГТ 2.1.1. ХҮН АМЫН СУУРЬ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ

Он	8-15 /6-15/ насын хүн ам			Сургуульд сурдаг хүн амын тоо			Суралцагчдын нийт хүн амд эзлэх хувь		
	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй
1990	404 842	201 578	203 264	378 486	196 434	182 052	93.5	97.4	89.6
2000	561 117	278 802	282 315	452 215	233 262	218 953	80.6	83.6	77.5
2010	460 537	233 665	226 872	443 984	220 754	223 230	96.4	94.5	98.4

Монгол Улсын иргэдийн суурь боловсролын хамран сургалтын өөрчлөлт нь 8-15 (6-15) насын хүн амын сургуульд суралцахгүй байгаатай шууд холбоотой байдаг. Иймээс энэхүү судалгаанд 2010 оны хүн амын тооллогын дүнг ашиглан хүүхдийн сургууль завсардалтыг авч үзлээ.

## 2.2. ХҮН АМЫН СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ

Монгол Улсын суурин хүн амын 16.6 хувийг 6-15 насын хүүхэд эзэлж байгаагийн дотор 2010 оны тооллогоор 6-15 насын хүн амын 3.6 хувь нь буюу 16553 хүүхэд сургуульд суралцахгүй байна.


Сургуульд суралцахгүй байгаа хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувь улсын дундаж 3.6 хувь байгаа бол Баян-Өлгийд хамгийн их буюу 8.5 хувь, Хөвсгөлд 5.8 хувь, Увсад 5.7 хувь, Өвөрхангайд 5.6 хувь, Архангайд 5.2 хувь байна. Харин Улаанбаатар хотод 2.4 хувь байна. Энэ судалгаанаас үзэхэд сургууль завсардалт Орхонд 2.0 хувь, Говьсүмбэрт 2.1 хувь буюу сургууль завсардалт бусад аймгаас бага байгаа мэт боловч энэ 2 аймгийн бараг бүх хүн аймгийн төвд (хотод) амьдардаг тул төлөөлөх боломжгүй юм (Хүснэгт 2.2.1). Сургуульд сурдаггүй нийт хүүхдэд эрэгтэйчүүд 63.0, эмэгтэйчүүд 37.0 хувийг тус тус эзэлж, эрэгтэй хүүхдийнх эмэгтэйгээс 26.0 пунктээр илүү байна.

6-15 настай нийт хүн амын хувьд сургуульд сурдаггүй хүүхдийн насын ангилал, хүйс, хот болон хөдөөгөөр (Хавсралт хүснэгт 2.1.9, зураг 2.2.2-2.2.4)-д харууллаа. Хөдөө орон нутагт аль ч насын хувьд завсардалт их байгаа нь харагдаж байна. Тухайлбал, 6 настай хүүхдийн хувьд хотод завсардалт 2.3 хувийг эзэлж байгаа бол хөдөөд 12.9 хувьд хүрч байна (Зураг 2.2.4). Эрэгтэй хүүхдийн сургууль завсардалтын төвшин бүх насанд эмэгтэй хүүхдээс дээгүүр байна.

6-15 насын сургуульд сурдаггүй нийт хүүхэд болон түүний дотор хүйсээр нь үзэхэд завсардалт нь 6 насанд хамгийн их байснаа жигд буурсаар 9 насанд хамгийн бага байснаа 10 наснаас эхлээд жигд өссөөр 15 насанд дахин хамгийн их болж байна. Зургаан насынханд завсардалт их байгаа нь эцэг, эхчүүд 6 настай хүүхдийг сургуульд бүрэн элсүүлэхгүй байгаа, ялангуяа хөдөө орон нутагт сургуулийн хичээлийн байрын хүрэлцээ муутай холбоотой юм. Арван таван насынханд сургууль завсардалт мөн их байгаа нь 2000 оноос өмнө сургууль завсардалт их байсантай холбоотой болно (Хүснэгт 2.2.1 - 2.2.6).

**ХҮСНЭГТ 2.2.1. СУРГУУЛЬД СУРДАГГҮЙ 6-15 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, АЙМАГ,  
НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН**


Аймаг, нийислэл	Нийт хүн ам	6-15 настай нийт	Нийт хүн амд 6-15 насны эзлэх хувь	Сургуульд сурдаггүй	
				Хүүхдийн тоо	Хувь
<b>БҮГД</b>	<b>2 647 545</b>	<b>460 537</b>	<b>17.4</b>	<b>16 553</b>	<b>3.8</b>
Архангай	84 078	17 569	20.9	915	5.2
Баян-Өлгий	85 232	20 648	24.2	1 764	8.5
Баянхонгор	75 690	15 853	20.9	777	4.9
Булган	53 065	10 163	19.2	324	3.2
Говь-Алтай	53 223	11 046	20.8	361	3.3
Дорноговь	57 930	10 437	18.0	294	2.8
Дорнод	68 873	12 222	17.7	344	2.9
Дундговь	38 543	7 958	20.6	239	3
Завхан	64 924	13 496	20.8	465	3.5
Өвөрхангай	100 444	20 977	20.9	1 172	5.6
Өмнөговь	60 855	10 056	16.5	303	3.1
Сүхбаатар	51 091	9 821	19.2	499	5.1
Сэлэнгэ	95 804	17 788	18.6	523	2.9
Төв	83 838	15 059	18.0	546	3.4
Үвс	72 906	17 236	23.6	981	5.7
Ховд	76 252	17 472	22.9	725	4.2
Хөвсгөл	114 331	226 68	19.8	1304	5.8
Хэнтий	65 335	131 40	20.1	348	2.7
Дархан-Уул	90 642	15 110	16.7	336	2.8
Улаанбаатар	1 154 290	164 222	14.2	3 982	2.4
Орхон	87 118	15 124	17.4	298	2
Говьсүмбэр	13 081	2472	18.9	53	2.1



ЗУРАГ 2.2.2. СУРГУУЛЬД СУРДАГГҮЙ 6-15 НАСНЫ ХОТЫН ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



ЗУРАГ 2.2.3. СУРГУУЛЬД СУРДАГГҮЙ 6-15 НАСНЫ ХӨДӨӨГИЙН ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Сургуульд сурдаггүй хүүхдийн тоо хөдөөд хотоос нэлээд олон байна. Тухайлбал хотод 6 настай нийт хүүхдийн 3.9 хувь нь сургуульд сурдаггүй байхад энэ үзүүлэлт хөдөөд хотоос 2.7, 7 настай хүүхэд 1.9, 8 настай хүүхэд 1.5 дахин тус тус их байна.

# ГУРАВЛУГААР БУЛЭГ

ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН,  
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ



Болд-эрдэж  
түүнч

1<sup>ж</sup> эхийн сургалт т. Нийдал  
Нийтийншиг

Нийтийншиг орж өрж чадах сургалт  
бүрийн цэвэр хөдөлгүүрт сурж  
хийн. Тэр эддээ хөдөлж, орж  
чадахгүйг орж нийн сийн сургалт  
тэж хийдлийн шинэ хувьлас  
шалж, эзлэг авах зэрээр бэлэн  
байж болгохын төслийн хийн  
Эцэг эх нийн сургалтадын  
чадах багасгүйгээ хийдлийн зам  
байж


Негдуулж алж орж чадах сургалт  
бүрийн цэвэр хөдөлгүүрт сурж  
хийн. Тэр эддээ хөдөлж, орж  
чадахгүйг орж нийн сийн сургалт  
тэж хийдлийн шинэ хувьлас  
шалж, эзлэг авах зэрээр бэлэн  
байж болгохын төслийн хийн  
Эцэг эх нийн сургалтадын  
чадах багасгүйгээ хийдлийн зам  
байж

### 3.1. ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН

Энэхүү судалгаанд хүн амын боловсролын төвшинг олон улсын жишиг, өмнөх тооллоготой зэрэгцүүлэхүйц байдлаар 10, түүнээс дээш насаар, бичиг үсгийн мэдлэгийг 15, түүнээс дээш насаар тус тус тооцож гаргасан болно.

2000 онд 10, түүнээс дээш насны боловсролтой хүн амын дотор бага боловсролтой 23.4 хувь, бүрэн бус дунд /суурь/ боловсролтой 25.1 хувь, бүрэн дунд боловсролтой 21.0 хувь, техник мэргэжлийн дунд боловсролтой 3.6 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 7.6 хувь, дээд боловсролтой 7.6 хувь байсан.

**ЗУРАГ 3.1.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН**



2010 онд 10, түүнээс дээш настай хүн амын дотор бага боловсролтой 15.8 хувь, бүрэн бус дунд /суурь/ боловсролтой 17.9 хувь, бүрэн дунд боловсролтой 32.0 хувь, техник мэргэжлийн дунд боловсролтой 2.8 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 5.7 хувь, дээд боловсролтой 18.3 хувь байна (Хавсралт хүснэгт 3.1.1, Зураг 3.1.1). 2010 оныг 2000 онтой харьцуулахад бага боловсролтой хүн амын тоо 7.6, бүрэн бус дунд боловсролтойнх 7.2 пунктээр тус тус буурсан, харин бүрэн дунд боловсролтой хүн амын тоо 11, дээд боловсролтойнх 10.7 пунктээр тус тус өссөн байна (Зураг 3.1.1). Энэ нь хүмүүс бага, бүрэн дунд боловсрол эзэмшээд зогсох бус улам дээд төвшний боловсрол эзэмших эрмэлзэл нэмэгдсэнтэй холбоотой юм.

2000-2010 онд бага, суурь, техник мэргэжлийн дунд болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын эзлэх хувь буурсан, харин бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өссөн байна. Энэ нь нэг талаас сүүлийн жилүүдэд хүн амын ихэнх нь бүрэн дунд боловсрол эзэмших, улмаар дээд сургуульд элсэн суралцах хүсэл, хандлага нэмэгдсэн, нөгөө талаас хувийн их, дээд сургууль, коллежийн тоо харьцангуй олон байгаагаас иргэдийн дээд сургуульд элсэн суралцах боломж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын хувьд 2000-2010 онуудад өсөлт нь бага байна. Энэ нь 1991 оноос тусгай мэргэжлийн дунд боловсролоор сургадаг сургалтын байгууллагын ихэнхийг мэргэжлийн анхан, дунд шатны болон дипломын дээд боловсрол эзэмшүүлдэг болгон өөрчилсөнтэй холбоотойгоос гадна нэлээд нь 1990-ээд оноос өмнө

тусгай мэргэжлийн дунд боловсрол эзэмшсэн хүн амын тоо насхилтаас болоод буурч байгаатай холбоотой юм.

Монгол Улсын дээд боловсролтой хүн амын тоо улсын дүнгээр 2010 онд огцом өссөний дотор сүүлийн 10 жилд буюу 2010 онд 2000 оныхос 2.8 дахин өсөж 252.4 мянга болжээ (Зураг 3.1.1). Энэ хугацаанд дээд боловсролтой хүн амыг хүйсээр нь ангилж үзэхэд тогтмол өссөн боловч 2000 оны хүн амын тооллогоор 10, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын 7.6 хувь нь, эмэгтэйн 7.7 хувь нь дээд боловсролтой байсан бол 2010 оны хүн амын тооллогоор харгалзан 15.4 хувь, 21.2 хувь болж, дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 5.8 пунктээр илүү болжээ (Зураг 3.1.4, 3.1.5). Ийнхүү боловсрол эзэмших төвшин нэмэгдэх тусам эрэгтэйчүүдийн хувийн жин буурч байна.


Дээд боловсролтой хүн амыг байршилаар нь авч үзэхэд 1963 оноос хөдөөгийн дээд боловсролтой хүн амын тоо хотынхос 6.6 дахин бага байснаа 2010 онд 7.4 дахин өссөний дотор дээд боловсролтой хүн амын тооны зөрүү хот, хөдөөд эрс ялгаатай байгааг харуулж байна (Зураг 3.1.6, 3.1.7).

Иймээс хөдөөг нарийн мэргэжлийн дээд боловсролтой хүн амаар илүү хангах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Түүнчлэн 2000 оноос эхлэн дээд боловсролтой эрэгтэйчүүдийн тоо нэлээд буурч байгааг иш үндэс болгон хүйсийн бодлого ч тавигдаж байна.

Дээд боловсролын салбарын сүүлийн 10 жилийн статистикийн нэгдсэн үзүүлэлтээс үзэхэд 2000-2001 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж 178, түүний дотор төрийн бус өмчийнх 41 байсан бол 2010-2011 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж 113 болж буурсны дотор төрийн бус өмчийнх 92 байна. Энэ хугацаанд дээд боловсролд суралцагчдын тоо 90.6 мянга байснаа 170.1 буюу 1.9 дахин өссөн байна. Дээд сургуульд суралцагчдын 61.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.


2000-2001 оны хичээлийн жилд дээд боловсролын салбарт 2.8 мянган багш ажиллаж байсан бол 2010-2011 оны жилээлийн жилд 4.2 мянга болж өсчээ.

### ЗУРАГ 3.1.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХОТЫН ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН



Хүн амын боловсролын төвшинг хот, хөдөөгөөр харьцуулан авч үзэхэд 2000 онд хотын хүн амын 17.5 хувь нь бага, 21.8 хувь нь бүрэн бус дунд, 27.5 хувь нь бүрэн дунд, 3.6 хувь нь техник мэргэжлийн дунд, 2.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 11.7 хувь нь дээд боловсролтой байсан бол 2010 онд харгалзан 10.8; 14.3; 37.6; 2.5; 6.5; 23.4 хувь болжээ (Хавсралт хүснэгт 3.1.2, 3.1.3, Зураг 3.1.2, 3.1.3).

**ЗУРАГ 3.1.3. АРАВ, ТҮҮНЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН**



2000 онд хөдөөд бага, бүрэн бус дунд, бүрэн дунд боловсролтой хүн амын тоо хотынхаас 10 гаруй пунктээр илүү байсан бол харин 2010 он гэхэд хотод бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын тоо хөдөөгөөс 10 пунктээр илүү болжээ.

Хүн амын боловсролын төвшинг хүйсээр нь авч үзэхэд 2000 онд эрэгтэйчүүдийн 23.8 хувь нь бага, 28.3 хувь нь бүрэн бус дунд /суурь/, 19.1 хувь нь бүрэн дунд, 3.9 хувь нь техник мэргэжлийн дунд, 5.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 7.6 хувь нь дээд боловсролтой байсан бол 2010 онд харгалзан тус тус 16.6, 20.3, 32.2, 3.1, 4.6, 15.4 хувь байна (Хавсралт хүснэгт 3.1.4, 3.1.5). Эмэгтэйчүүдийн хувьд 2000 онд 23.1 хувь нь бага, 22.1 хувь нь бүрэн бус дунд /суурь/, 22.8 хувь нь бүрэн дунд, 3.4 хувь нь техник мэргэжлийн дунд, 9.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 7.7 хувь нь дээд боловсролтой байсан бол 2010 онд харгалзан тус тус 15.0; 15.6; 31.9; 2.6; 6.9; 21.2 хувь болжээ (Зураг 3.1.5).

2010 оныг 2000 онтой харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд бүрэн дунд боловсролтой 13.1, дээд боловсролтой 7.8 пунктээр, эмэгтэйчүүдийн хувьд бүрэн дунд боловсролтой 9.1, дээд боловсролтой 13.5 пунктээр өссөн байна. Мөн дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 5.5 пунктээр илүү өсчээ.

ЗУРАГ 3.1.4. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭРЭГТЭЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН  
ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН




ЗУРАГ 3.1.5. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭМЭГТЭЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН  
ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН



Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд 2010 онд 10, түүнээс дээш насны боловсролтой хүн амьн дотор бүрэн дунд, дээд болон суурь боловсролтой хүн ам давамгайлж, харин техникийн болон мэргэжлийн дунд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амьн эзлэх хувийн жин нэлээд доогуур байна (Зураг 3.1.6).

Иймд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг цаашид хөгжүүлэхэд техникийн болон мэргэжлийн дунд боловсролтой хүн амьн хувийн жинг нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна.

**ЗУРАГ 3.1.6. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, УЛС,  
ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**



Хүн амын боловсролын төвшинг байршил /хот, хөдөө/-аар ангилж үзэхэд мөн л суурь, бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын хувийн жин давамгайлж байна. Түүнчлэн хотод бүрэн дунд боловсролтой хүн амын хувийн жин хөдөөгөөс 1.9 дахин, дээд боловсролтой хүн амынх 3.3 дахин өндөр, харин бага боловсролтой хүн амын хувийн жин хөдөөд, хотоос 1.8 дахин, суурь боловсролтой хүн амынх 2.5 дахин тус тус илүү байна.

Үүнээс үзэхэд хөдөөд бага болон суурь боловсролтой хүн амын хувийн жин хотоос нэлээд илүү, харин бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын хувийн жин эсрэгээр хотод нэлээд илүүг харуулж байна. Энэ нь эцэг, эхчүүд хүүхдээ суурь боловсрол эзэмших хүртэл хөдөө сургаад, суурь боловсрол эзэмшин төгсмөгц заримыг нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд элсүүлэн сургадаг, мөн зарим нь хүүхдээ хөдөөнөөс хотруу шилжүүлэн бүрэн дунд сургуульд үргэлжлүүлэн сургадаг хандлага бий болсонтой холбоотой юм.

Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын төвшинг хүйсээр нь ангилж үзэхэд бага, суурь, бүрэн дунд боловсролтой эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйгээс илүү, харин тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйгээс илүү байна. Техникийн болон мэргэжлийн дунд боловсролын хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувийн жингийн ялгаа бага байна (Зураг 3.1.7).

ЗУРАГ 3.1.7. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН,  
ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ, ХУВИАР, 2010 ОН



Боловсролтой хүн амын тоо 20-24 насанд, боловсролгүй хүн амын тоо 10-14 насанд тус тус хамгийн олон байна (Хүснэгт 3.1.1). Монгол улсад 3581 докторын зэрэгтэй хүн байгаагийн дотор 45-49, 55-59 наасны бүлэгт хамгийн олон байна. Магистр зэрэгтэй хүн 25-29, 30-34 наасны бүлэгт, харин дипломын болон бакалаврын боловсролтой хүн 20-24, 25-29 наасны бүлэгт олонхийг бүрдүүлж байна.

Тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүсийн хувьд 40-44, 45-49 нас гол жин дарж байгаа нь нарийн мэргэжлийн боловсон хүчин хөгшрөх хандлагатай болсныг харуулж байна. Энэ нь 1995 оноос манай улсын дээд боловсролын тогтолцоонд өөрчлөлт орж, их, дээд сургууль, коллежид дипломын дээд, баклавар, магистр, докторын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэдэг, тусгай мэргэжлийн дунд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхгүй болсонтой холбоотой. Иймээс тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүсийн дийлэнх нь энэхүү өөрчлөлтөөс өмнө төгссөн тус насхилт нь өндөр байгаа юм.

Сүүлчийн жилүүдэд улс орны их бүтээн байгуулалт, олборлох болон боловсруулах үйлдвэрүүд байгуулахтай холбогдон уул уурхай, ашигт малтмал, барилга, замын чиглэлээр инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилтны хэрэгцээ, улам бүр нэмэгдэж байна.

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос хийсэн судалгаанаас үзэхэд ойрын 5 жилд боловсруулах аж үйлдвэрийн салбарт 12 мянга гаруй ажиллагсад шаардагдах бөгөөд үүнээс инженер техникийн 2600 гаруй ажилтан шаардагдахаар тооцоо гарчээ. Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрт ойрын 5 жилд 21 мянга гаруй ажлын байр гaraхаас 3200 инженер техникийн ажилтны хэрэгцээ байна. Эндээс харахад ойрын 5 жилд нийтдээ 40 орчим мянган ажиллагсад, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтан шаардагдах тооцоо гарч байна. Үүнийг ганц ШҮТИС-ийн төгсөгчдөөс бэлтгэнэ гэвэл 5 жил биш 15 жил шаардагдах юм. Иймд олборлох, боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлдэх асуудалд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна.

2010 оны хүн амын тоологоор арав, түүнээс дээш наасны суурин хүн амын боловсролын төвшинг аймаг хотоор ялгаж үзэхэд дээд болон бүрэн дунд боловсролтой хүн амын хувийн жин мөн л Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр аймагт бусдаас өндөр байна. Боловсролын бусад төвшний хувьд аймгуудад онцын ялгаа бага, харин бага болон суурь боловсролтой хүн амын хувьд Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймагт бусдаас хүн амын хувийн жин бага байна (Хүснэгт 3.1.3).

**ХҮСНЭГТ 3.1.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ СУУРИН ХҮН АМЫН ТОО,  
БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН**

Аймаг, нийслэл	Боловсролын төвшингөөр							
	Боловс- ролгүй	Боловс- ролтой	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага
<b>БҮГД</b>	<b>7.5</b>	<b>92.5</b>	<b>18.3</b>	<b>5.7</b>	<b>2.8</b>	<b>32.0</b>	<b>17.9</b>	<b>15.8</b>
Архангай	12.3	87.7	7.9	4.0	2.5	24.1	23.7	25.6
Баян-Өлгий	14.2	85.8	9.8	5.3	3.9	18.1	20.2	28.6
Баянхонгор	11.6	88.4	8.4	3.6	3.0	21.1	27.7	24.5
Булган	8.3	91.7	9.6	5.3	3.3	25.5	26.0	22.0
Говь-Алтай	5.0	95.0	10.4	4.7	3.9	21.2	23.8	23.9
Дорноговь	8.2	91.8	14.2	6.1	3.4	27.1	23.9	17.1
Дорнод	8.9	91.1	11.9	6.1	3.7	28.0	25.1	16.5
Дундговь	13.2	86.8	9.2	4.8	2.8	16.4	26.6	26.8
Завхан	12.8	87.2	10.8	4.7	2.9	22.5	9.4	23.2
Өвөрхангай	12.7	87.3	7.7	3.9	2.5	20.1	23.6	29.4
Өмнөговь	8.1	91.9	14.3	4.6	3.4	25.2	25.7	18.6
Сүхбаатар	15.7	84.3	9.0	4.8	4.6	17.5	25.4	23.0
Сэлэнгэ	7.1	92.9	12.3	6.6	4.3	32.6	21.8	15.3
Төв	8.6	91.4	10.1	5.5	4.3	25.8	26.2	19.4
Үвс	14.8	85.2	9.5	4.8	4.0	17.5	24.1	25.3
Ховд	11.9	88.1	10.6	4.9	3.0	25.1	21.6	22.9
Хөвсгөл	11.8	88.2	8.3	4.2	2.7	23.4	23.0	26.6
Хэнтий	11.1	88.9	10.7	4.4	3.6	22.5	27.0	2.1
Дархан-Уул	5.0	95.0	18.0	7.8	3.3	37.7	16.5	11.8
Улаанбаатар	3.7	96.3	27.1	6.4	2.1	40.8	11.3	8.6
Орхон	5.4	94.6	19.7	7.0	3.3	35.3	16.8	12.4
Говьсүмбэр	7.1	92.9	15.8	6.2	2.5	29.3	22.7	16.3

## 3.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ

2010 оны хүн амын тооллогоор манай улсад 10, түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй хүн ам 103.0 мянга, үүнээс 80.4 мянга буюу 78.0 хувь нь ямар нэгэн төвшний боловсрол эзэмшсэн, 22.6 мянга буюу 22.0 хувь нь боловсролгүй байна.

Боловсролтой хүн амын 7.9 мянга буюу 7.7 хувь нь дээд, 6.4 мянга буюу 6.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.6 мянга буюу 3.5 хувь нь техникийн болон мэргэжлийн дунд, 25.8 мянга буюу 25 хувь нь бүрэн дунд, 19.2 мянга буюу 18.6 хувь нь суурь, 17.5 мянга буюу 17 хувь нь бага боловсролтой байна (Хүснэгт 3.2.1). Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүний тоо эмэгтэйгээс 10.8 мянган хүнээр олон байна.


Хөгжлийн бэрхшээлтэй боловсролгүй хүн амын 7.6 мянга буюу 33.7 хувь нь бичиг үсэг мэддэг, 15.0 мянга буюу 66.3 хувь нь бичиг үсэг мэддэггүй байна. Үүнээс үзэхэд 2010 оны байдлаар 10, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 85.4 хувь нь бичиг үсэг мэддэг байна. Энэ нь манай улсын хүн амын бичиг үсгийн мэдлэгийн төвшин (Хүснэгт 3.2.1)-тэй харьцуулахад 12.9 хувиар доогуур байна.

2010 онд хөгжлийн бэрхшээлтэй хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгийг хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн 78.9 эмэгтэйчүүдийн 76.8 хувь нь боловсролтой, эрэгтэйн 21.1 хувь, эмэгтэйн 23.2 хувь нь боловсролгүй байна (Зураг 3.2.1).

Боловсролгүй эрэгтэйн 34.7 хувь, эмэгтэйн 32.6 хувь нь бичиг үсэг мэддэг байхад эрэгтэйн 65.3, эмэгтэйн 67.4 хувь нь бичиг үсэг мэддэггүй байна. Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд боловсролтой эрэгтэйн хүн амын хувийн жин эмэгтэйгээс 2.1 хувиар илүү байхад харин бичиг үсэг мэддэггүй эмэгтэй хүн амын хувийн жин эрэгтэйгээс 2.1 хувиар дээгүүр байна.

Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд эрэгтэйчүүдийн 86.3 хувь, эмэгтэйн 84.4 хувь нь бичиг үсэг мэддэг байна (Хүснэгт 3.2.1, 3.2.2).

#### ЗУРАГ 3.2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУЙС, ХУВИАР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй, боловсролгүй иргэдийн хувийн жинг насны ангиллаар авч үзэхэд 10-14 насанд 54.8 хувь буюу хамгийн өндөр, 15-19 насанд 36.3 хувь байснаа буураад 50-54 насанд 10.3 хувь буюу хамгийн бага, 55, түүнээс дээш насанд 16.9 хувь байна (Хүснэгт 3.2.1).

Арав, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын боловсролын төвшинг аймаг, нийслэлээр үзэхэд 2010 онд Улаанбаатар хотод 87.5, Дархан-Уулд 85.8, Орхонд 85.3 хувь, бусад аймагт 62.8-80.3 хувь нь боловсролтой байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй боловсролгүй иргэдийн хувийн жин Увсад 37.2, Дундговьд 36.6, Сүхбаатарт 34.9, Архангайд 33.3 хувь бусдаас өндөр байхад Улаанбаатар хотод 12.5, Дархан-Уулд 14.2, Орхонд 14.7 хувь бусад аймгаас бага байна (Хүснэгт 2.2.2.).

Хөгжлийн бэрхшээлтэй дээд боловсролтой хүний хувийн жин Улаанбаатар хотод 13.8, Орхонд 8.7 хувь бусад аймгаас илүү, бүрэн дунд боловсролтой болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн жин Улаанбаатар хотод 44.5, Орхонд 43.1, Дархан-Уулд 41.9 хувь бусдаас мөн илүү байна. Гэтэл бага боловсролын хувьд Улаанбаатар хотод 10.9, Орхонд 10.9, Дархан-Уулд 12.8 хувь бусдаас бага, харин Төвөрхангайд 27.7, Хөвсгөлд 26.1, Баян-Өлгийд 24 хувь бусдаас өндөр байна.

Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэг хөдөөд доогуур байдаг нь харагдана (Хүснэгт 3.2.1).

**ХҮСНЭГТ 3.2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН БАЙДЛААР, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН**

Аймаг, нийслэл	Боловсролын төвшин								
	Боловсролтой хүн ам	Боловсролгүй хүн ам	Дээд дунд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	
БҮГД	78.0	22.0	7.7	6.2	3.5	25.1	18.6	16.9	
Архангай	66.7	33.3	3.3	4.0	2.6	16.6	17.7	22.5	
Баян-Өлгий	74.0	26.0	3.2	5.3	5.1	17.2	19.0	24.0	
Баянхонгор	71.1	28.9	3.2	3.2	3.3	18.3	21.9	21.3	
Булган	73.7	26.3	4.6	5.7	3.9	18.8	21.5	19.2	
Говь-Алтай	71.8	28.3	4.5	4.0	4.5	16.6	18.9	23.1	
Дорноговь	75.7	24.3	5.7	4.9	3.2	18.8	22.9	20.2	
Дорнод	77.5	22.5	4.6	5.7	3.2	22.8	25.2	15.9	
Дундговь	63.4	36.6	3.1	4.0	2.1	12.9	20.9	20.3	
Завхан	69.7	30.3	3.3	4.4	3.6	19.2	20.9	18.3	
Өвөрхангай	70.4	29.6	3.2	3.1	2.9	15.0	18.4	27.7	
Өмнөговь	73.4	26.6	5.6	5.1	3.0	15.1	21.6	22.9	
Сүхбаатар	65.1	34.9	3.9	4.0	4.2	11.9	19.6	21.5	
Сэлэнгэ	80.3	19.7	5.3	6.8	5.4	25.6	21.4	15.8	
Төв	72.2	27.8	4.3	4.6	5.0	17.9	21.5	18.9	
Үвс	62.8	37.2	3.7	4.1	4.2	13.5	18.2	19.0	
Ховд	68.4	31.6	4.3	4.1	3.8	18.9	17.5	19.8	
Хөвсгөл	70.7	29.3	3.1	3.7	2.7	16.2	19.0	26.1	
Хэнтий	74.0	26.0	4.7	4.0	4.0	16.9	24.8	19.6	
Дархан-Уул	85.8	14.2	8.4	9.5	4.4	32.4	18.4	12.8	
Улаанбаатар	87.5	12.5	13.8	8.5	3.1	36.0	15.2	10.9	
Орхон	85.3	14.7	8.7	8.7	3.8	34.4	18.8	10.9	
Говьсүмбэр	77.3	22.7	4.9	5.3	1.2	20.0	27.8	18.0	


2010 онд 10, түүнээс дээш насны хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгийг насны бүлгээр авч үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй боловсролтой хүн амын тоо 25-29 насны бүлгээс эхлэн нэмэгдсээр 45-49 насны бүлэгт хамгийн өндөр болсон байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй боловсролтой хүн ам 25-29 насны бүлэгт 66.6 хувь байхад 35-39 насны бүлэгт 81.9 хувь, 45-49 насны бүлэгт 86.2 хувь болж өсчээ (Хүснэгт 3.2.2).

### 3.3. БОЛОВСРОЛ БА ШАШИН

Шашин бол зөвхөн сүсэг бишрэл, итгэл үнэмшил төдийгүй хүн төрөлхтөний соёл, оюун санааны хөгжил, төлөвшлийн чухал үзэгдэл байдаг. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээс үндэслэн хүн амын шашин шүтлэг, боловсролын төвшний хамаарлыг судлан үзэв. Монгол оронд ардчилсан хөдөлгөөн өрнөж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх болсноор шашин шүтлэгийг чөлөөтэй болгосон. Шашныг ухамсартайгаар шүтэх нь түүний нөлөөнд хэт автахгүй, мухар сүсэг бишрэлээс хол байх сайн талтай. Иймд чухам ямар боловсролтой хүмүүсийн дотор шашинтан зонхицж байна вэ гэдгийг авч үзэх нь нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой юм.

Судалгаанаас үзэхэд шашинтан, боловсролын төвшин хоёрын хооронд ерөнхийдөө зэрэг хамаарал ажиглагдлаа. Боловсролын төвшин ахижад шашинтны хувь хэмжээ дагаж өсөх хандлагатай байна. Зураг 3.3.1-д хэвтээ тэнхлэгт боловсролын төвшинг, босоо тэнхлэгт шашинтан хүний эзлэх хувийн жинг үзүүлсэн.

ЗУРАГ 3.3.1. БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМД ШАШИНТНЫ ЭЗЛЭХ ХУВЬ, 2010 ОН



Энэ нь нэг талаас хүний нас ахиж, нас буянаа нэмэх, залбирал үйлдэх шашны боловсролын шаардлага гарч ирдэгтэй холбоотой боловч боловсролын төвшин өндөр байгаа учраас ухамсартай, зохистой хандлага гэж үзэж болно.

Арван тав, түүнээс дээш настай Монголын нийт хүн амын 61.4 хувь нь ямар нэг шашинтан, 38.6 хувь нь шүтлэггүй байна. Шашинтны үнэмлэхүй олонх буюу 86.2 хувь нь буддаг шүтдэг байхад Христийн шашинтан 3.5 хувь, ислам шашинтан 4.9 хувь тус тус эзэлж байна.

Боловсролгүй хүмүүс шашинтан байх нь харьцангуй бага байна. Боловсролгүй нийт хүний 58.8 хувь нь шашинтан байхад магистрын боловсролтой хүмүүсийн 69.3 хувь нь шашинтан байна (Хавсралт хүснэгт 2.3.1).

Монгол орон залуучуудын орон бөгөөд залуучуудын дотор шашинтны эзлэх хувь төдийлөн өндөр биш. Үүнийг суурь, бүрэн дунд, техник мэргэжлийн төвшний боловсролтой хүмүүсийн эзлэх хувь бусдаас харьцангуй доогуур байгаагаас харж болно. Бага боловсролтой хүмүүсийн дотор шашинтны эзлэх хувь 65.5 хувь байсан бол суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүст шашинтны эзлэх хувь 56-59 болж буурч байна.

Энэ нь өсвөр насыхан суурь боловсрол, түүний дотор байгаль шинжлэлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болсноор өртөнцийг үзэх шинжлэх ухааны үзэл бодол бүрэлдэн эхэлж байгаатай холбоотой байж болох юм.

Сүүлийн үед бөө удган олноор төрж нэлээдгүй нь ард түмний дотор нэр нөлөөтэй болж байгаа боловч бөөгийн шашинтны эзлэх жин 4.7 оос хэтрэхгүй байна.

Хүн амын шашинтныг хүйсээр нь ангилж үзвэл эмэгтэйчүүд ижил боловсролтой эрэгтэйчүүдээс боловсролын төвшин бүрт 10 орчим пунктээр илүү байна (Зураг 3.3.2, Хавсралт хүснэгт 3.3.2-3.3.3).

### ЗУРАГ 3.3.2. БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМД ШАШИНТНЫ ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2010 ОН




Ер нь шүтлэг бол хувь хүний итгэл үнэмшил, сэтгэл зүйн асуудал байдаг бөгөөд сэтгэлийн дайчин давшингүй буюу эсвэл сул дорой байдлаас хамаардаг онцлогтойгоос эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байдаг гэж үзэж болно.

### 3.4. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Хүн амын бичиг үсгийн мэдлэг байнга өсөж (Зураг 3.4.1) ирсний дотор бичиг үсэгтний хувь 1921 онд 2.1 байсан бол 1944 онд 27.3 хувь, 1956 онд 70.5 хувь болж огцом өсөөд 1979 онд 92.7 хувь, 1989 онд 96.5 хувь, 2000 онд 97.8 хувь, 2010 онд 98.3 хувь болж тус тус өсчээ (Зураг 3.4.1).

ЗУРАГ 3.4.1. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ОН, ХУВИАР



Энэ нь Монгол Улсын анхны (1924 он) болон 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудад Монгол Улсын иргэдийг эрэгтэй, эмэгтэй, шашин шүтлэг, өмч хөрөнгийн хэмжээ, нийгмийн гарал үүслийг ялгаварлахгүйгээр үнэ төлбөргүй сургах тухай заалт оруулж, түүнийг нь үе үеийн төр, засгийн газрууд ээлж дараатайгаар хэрэгжүүлсний үр дүн юм.


Тухайлбал хүн амын бичиг үсгийн мэдлэг 1945-1955 онуудад огцом өссөн нь 1941 онд МАХН-ын Төв хорооноос иргэдийг нийтээр нь бичиг үсэгт түргэн сургах зорилт дэвшүүлэн тавьсан, 1955 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв Хорооноос “Насанд хүрэгсдийг сургах оройн сургууль байгуулах тухай” хамтарсан тогтоол гаргаж амьдралд амжилттай хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

Монгол Улсын 15, түүнээс дээш насны боловсролтой болон боловсролгүй хүн амын хувийн жинг 2010 оны тооллогын дүнг үндэслэн 21 аймаг, нийслэлээр үзэхэд боловсролтой хүн амын эзлэх хувь Дундговьд 89.4, Сүхбаатарт 87.4, Увсад 89.4, бусадад нь 90-ээс дээш хувьтай байна. Үүний дотор Улаанбаатар хотод 98.9, Дархан-Уулд 97.9, Орхонд 97.8, Сэлэнгэд 96.9, Говьсүмбэрт 95.9 хувь байна (Зураг 3.2.3). Эндээс харвал нийслэл болон том хот төвтэй аймагт боловсролтой хүн амын тоо өндөр байна.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн төвшинг аймаг, нийслэлээр ангилан үзэхэд хамгийн өндөр хувьтай нь Өмнөговьд 98.4, Сэлэнгэд 98.4, Дорнговьд 98.0, Булганд 97.6, Төвд 97.5, Баян-Өлгийд 97.4 хувь тус тус байна. Харин Сүхбаатарт 94.0, Архангайд 95.9, Дундговьд 96.0, Увсад 96.5 хувь байгаа нь бичиг үсгийн мэдлэгийн төвшин харьцангуй доогуур байна (Зураг 3.2.4).

Улаанбаатар болон хотожсон аймгууд болох Орхон, Дархан-Уул, Говьсүмбэрт хүн амын бичиг үсгийн мэдлэг улсын дунджаас дээгүүр байна.

**ЗУРАГ 3.4.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ,  
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН**



“Хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэг” сэдэвчилсэн судалгаагаар 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн төвшинг 1979-2010 оны хоорондох тооллогын дүнг ашиглан олон улсын аргачлалын дагуу хувиар болон индексчлэн гаргалаа. Энэхүү үнэлгээний дүнгээс үзэхэд Монгол Улсын хүн амын бичиг үсгийн мэдлэгийн хувь 1979 онд 92.7, 2000 онд 97.8, 2010 онд 98.3 болж тус тус өссөн (Хүснэгт 3.2.2) байна.

Манай улсын хүн амын бичиг үсгийн боловсролыг хүйсээр нь судлан үзэхэд 1979-2000 онд эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн төвшин эмэгтэйчүүдийнхээс 1-6.7 пунктээр дээгүүр байснаа 2010 онд 0.1 хувиар доогуур болжээ.

Ийнхүү Монгол улс хүн ам, бичиг үсгийн мэдлэгээрээ дэлхийн тэргүүлэх орнуудын нэгд зүй ёсоор оржээ.

# ДОРӨВЛҮГЭЭР БУЛЭГ

ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ,  
БОЛОВСРОЛ





## 4.1. ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

2000 оны хүн амын тооллогын дүнгээс үзэхэд 15, түүнээс дээш насын ажил эрхэлдэг хүний эзлэх хувь улсын хэмжээнд 51.1 хувь, хотод 40.7 хувь, хөдөөд 66.0 хувь, хүйсийн хувьд эрэгтэй 56.1 хувь, эмэгтэй 46.3 хувь байжээ.

Арван жилийн дараа 2010 оны тооллогын дүнгээр ажил эрхэлдэг хүн амын 15, түүнээс дээш насы нийт хүн амд эзлэх хувь 47.8 болж 3.3 пунктээр буурсны дотор эрэгтэйчүүдийнх 52.8, эмэгтэйчүүдийнх 43.0 хувь болж, мөн тус бүр 3.3 пунктээр буурчээ (Хавсралт хүснэгт 4.1.1-4.1.3). Гэтэл энэ хугацаанд Засгийн газраас хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, гадаадын тусламж дэмжлэг авах зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн боловч хүн амын ажил эрхлэлт төдийлөн нэмэгдээгүй байна.


Ажил эрхэлдэг хүн амыг боловсролын төвшингээр нь авч үзэхэд 2000 онд 12.3 хувь нь дээд, 10.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, 5 хувь нь техник мэргэжлийн дунд, 21.6 хувь нь бүрэн дунд, 30.6 хувь нь бүрэн бус дунд буюу суурь, 15.7 хувь нь бага боловсролтой байжээ. Эндээс үзэхэд ажил эрхэлдэг хүн амын дийлэнх нь буюу 52.2 хувь нь бүрэн болон бүрэн бус дунд боловсролтой, харин 4.1 хувь боловсролгүй, түүний дотор 62.0 хувь нь бичиг үсэг мэддэг, 38.0 хувь нь бичиг үсгийн мэдлэггүй байжээ (Зураг 4.1.2).

2010 оны хүн амын тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насын хөдөлмөр эрхэлдэг хүн амын 29.2 хувь нь дээд, 7.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.6 хувь нь техникийн болон мэргэжлийн дунд, 31.4 хувь нь бүрэн дунд, 16.2 хувь нь суурь, 8.6 хувь нь бага боловсролтой байна (Зураг 4.1.1).

2010 оныг 2000 онтой харьцуулахад бага, бүрэн бус дунд /суурь/, техник мэргэжлийн дунд, тусгай мэргэжлийн дунд болон бүрэн бус дээд боловсролтой хүн амын ажил эрхлэлт буурсан, харин бүрэн дунд болон дээд боловсролтой ажил эрхлэгчдийн тоо огцом өссөн байна. Тухайлбал, дээд боловсролтой хүн амын хувийн жин 2000 оныхоос 2.4 дахин өсчээ (Зураг 4.1.1). Энэ нь сүүлийн 10 жилд бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын тоо нэлээд өссөнтэй холбоотойгоос гадна хөдөлмөрийн зах зээлд бүрэн дунд болон дээд боловсролтой хүний эрэлт бусдаас илүү байгааг харуулж байна.


Ажил эрхэлдэг хүмүүсийн хувьд 2000 онд 4.1 хувь нь боловсролгүй, үүний 62 хувь нь бичиг үсэг мэддэг байсан бол 2010 онд 3.5 хувь нь боловсролгүй, үүний 68.0 хувь нь бичиг үсэг мэддэг болжээ.

**ЗУРАГ 4.1.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН**




Ажил эрхэлдэг хүн амын боловсролын төвшинг хүйсээр нь ангилж үзэхэд 2010 онд бага, бүрэн бус дунд /суурь/ боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь 2000 оныхоос 1.7-1.8 дахин буурсан, эмэгтэйчүүдийн хувьд мөн л бага, суурь боловсролтой хүн амын эзлэх хувь тус бүр 1.8 дахин буурсан, харин дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь 3.1 дахин өссөн байна (Зураг 4.1.2, 4.1.3).

**ЗУРАГ 4.1.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН**




**ЗУРАГ 4.1.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН**



2010 онд хөдөөд ажил эрхэлдэг хүн амын 8.3 хувь нь боловсролгүй, үүний 67.8 хувь нь бичиг үсэг мэддэг байхад хотод 0.8 хувь нь боловсролгүй, үүний 69.3 хувь нь бичиг үсэг мэддэг нь боловсролгүй хүн амын ажил эрхлэлт хот, хөдөөд нэлээд ялгаатайг илэрхийлж байна. Энэ нь хөдөөгийн ажлын байрны ихэнх нь мал аж ахуй, газар тариалан байдаг бөгөөд эдгээрт нарийн мэргэжил, ур чадвар бага шаардагддагтай холбоотой байна.

2010 оны тооллогоор ажил эрхэлдэг боловсролгүй хүн амын 68.4 хувь эрэгтэй, 31.6 хувь нь эмэгтэй байна. Үүнээс үзэхэд боловсролгүй эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс 36.8 хувиар дээгүүр байна (Зураг 4.1.4).

**ЗУРАГ 4.1.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛГҮЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН**



2010 онд арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын боловсролын төвшинг аймаг, хотоор нь үзэхэд Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр аймаг дээд боловсролтой (26.8-43.8%) болон бүрэн дунд боловсролтой (34.5-38.3%) ажил эрхэлдэг хүн ам бусад аймгаас олон байхад Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Булган, Сүхбаатар аймагт дээд боловсролтой ажил эрхэлдэг хүн (11.6-14.4%) бусад аймгаас бага байна (Хүснэгт 4.1.1).

**ХҮСНЭГТ 4.1.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, АЙМАГ НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН**

Аймаг, нийслэл	Боловсролтой	Боловсролгүй	Боловсролтой					
			Дээд боловсрол	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага
<b>БҮГД</b>	<b>96.5</b>	<b>3.5</b>	<b>29.2</b>	<b>7.4</b>	<b>3.6</b>	<b>31.4</b>	<b>16.2</b>	<b>8.6</b>
Архангай	92.0	8.0	11.6	5.0	3.3	25.2	25.8	21.1
Баян-Өлгий	92.0	8.0	18.0	8.4	5.2	17.9	17.4	25.0
Баянхонгор	93.1	6.9	13.1	5.1	3.7	23.7	30.8	16.8
Булган	95.7	4.3	14.4	6.8	4.0	29.5	27.0	14.0
Говь-Алтай	93.3	6.7	16.7	6.5	5.0	22.7	25.3	17.1
Дорнговь	95.7	4.3	22.0	7.7	4.3	28.9	23.7	9.0
Дорнод	95.7	4.3	22.8	8.5	4.4	32.6	20.3	7.0
Дундговь	90.6	9.4	14.6	6.3	3.3	19.3	28.3	18.8
Завхан	92.0	8.0	19.1	7.2	4.0	24.2	22.4	15.2
Өвөрхангай	92.3	7.7	12.9	5.6	3.2	23.1	24.7	22.8
Өмнөговь	96.3	3.7	19.5	5.5	3.9	30.3	26.5	10.5
Сүхбаатар	87.3	12.7	13.9	5.8	5.5	19.2	27.1	15.8
Сэлэнгэ	97.8	2.2	20.7	8.7	5.6	37.6	19.1	6.2
Төв	95.7	4.3	15.0	7.4	5.5	28.7	27.1	11.9
Увс	90.7	9.3	16.4	7.0	5.5	21.2	23.0	17.6
Ховд	93.7	6.3	19.3	7.7	4.4	27.0	21.2	14.0
Хөвсгөл	92.3	7.7	12.9	5.7	3.2	27.0	22.4	21.1
Хэнтий	94.0	6.0	18.0	6.1	4.3	27.2	26.2	12.2
Дархан-Уул	98.8	1.2	31.0	11.0	4.4	37.3	11.9	3.1
Улаанбаатар	99.6	0.4	43.8	7.8	2.7	36.3	7.5	1.5
Орхон	98.9	1.1	32.0	9.9	4.6	38.3	11.2	3.0
Говьсүмбэр	97.3	2.7	26.8	8.6	3.5	34.5	17.4	6.3



## 4.2. АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛГҮЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн ам гэдэгтэнэ насны ажилгүйчүүдийн тоон дээр эдийн засгийн идэвхгүй хүн амыг оролцуулан тооцсон болно.

2010 оны тоологоор 15, түүнээс дээш насны суурин хүн амын 52.2 хувь нь ажил эрхлэхгүй байгаагийн дотор 12.7 хувь нь дээд, 5.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, 2.7 хувь нь техникийн болон мэргэжлийн дунд, 40.2 хувь нь бүрэн дунд, 22.0 хувь нь суурь, 11.8 хувь нь бага боловсролтой, 9.5 хувь нь боловсролгүй байна. Боловсролгүй хүн амын 67.6 хувь нь бичиг үсэг мэддэг, 32.4 хувь нь бичиг үсэг мэддэггүй байна.


Хотын хүн амын 20.7 хувь, хөдөөгийн хүн амын 11.1 хувь нь ажил эрхэлдэггүй байна (Зураг 4.2.2). Хүйсээр нь ангилж үзэхэд эрэгтэйчүүдийн 47.2 хувь, эмэгтэйчүүдийн 56.3 хувь нь ажил эрхлэхгүй байна. Ажил эрхэлдэггүй эрэгтэй хүн амын 10.4 хувь дээд, 4.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.0 хувь нь техникийн болон мэргэжлийн дунд, 40.1 хувь нь бүрэн дунд, 25.3 хувь нь суурь, 11.7 хувь нь бага боловсролтой байхад, эмэгтэйчүүдийн 14.5 хувь нь дээд, 6.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 2.5 хувь нь техникийн болон мэргэжлийн дунд, 40.3 хувь нь бүрэн дунд, 19.4 хувь нь суурь, 11.9 хувь нь бага боловсролтой байна (Зураг 4.2.3).

Ажил эрхэлдэггүй хүн амын боловсролын төвшинг хүйсээр нь харьцуулан үзэхэд 2010 оны байдлаар дээд боловсролоос бусад боловсрол /бага, суурь, бүрэн дунд, техник мэргэжлийн дунд, тусгай мэргэжлийн дунд/-той эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх хувь ойролцоо, харин ажил эрхэлдэггүй дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйгээс 9.1 хувиар илүү байна. Харин бүрэн дунд боловсролтой эрэгтэй, эмэгтэй хүний эзлэх хувийн жин 40 хувиас давж байгааг анхааран үзүүштэй юм. Энэ нь эцэг, эхчүүд эмэгтэй хүүхдээ боловсролтой болгох хүсэл, хандлага нэмэгдсэнтэй ч холбоотой байж болох юм.

Арван тав, түүнээс дээш насны боловсролгүй бөгөөд ажил эрхэлдэггүй хүн амын бичиг үсгийн мэдлэгийг судлан үзэхэд 2000 онд 51.5 мянган хүний 57.4 хувь нь бичиг үсэг мэддэг, 42.6 хувь нь бичиг үсэг мэддэггүй байсан бол 2010 онд ажил эрхэлдэггүй 49.5 мянган хүний 53.7 хувь нь бичиг үсэг мэддэг, 46.3 хувь нь бичиг үсэг мэддэггүй болжээ. (Зураг 4.2.1).

Ажил эрхэлдэггүй, боловсролгүй хүн амыг хүйсээр нь авч үзэхэд 2000 онд 18.5 мянган эрэгтэйн 59.2 хувь нь, 32.9 мянган эмэгтэйн 56.4 хувь нь бичиг үсэг мэддэг байсан бол 2010 онд 21.9 мянган эрэгтэйн 53.7 хувь нь бичиг үсэг мэддэг 27.6 мянган эмэгтэйн 53.7 хувь бичиг үсэг мэддэг байна. Бичиг үсгийн мэдлэгтэй ажил эрхэлдэггүй эмэгтэй эрэгтэйгээс 2000 онд 2.6 хувиар илүү байснаа 2010 онд бичиг үсгийн мэдлэгийн төвшин адил болжээ.


**ЗУРАГ 4.2.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ, БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР, 2000, 2010 ОН**



2000, 2010 онд ажил эрхэлдэггүй хүн амын дийлэнх буюу 22.0-40.2 хувийг суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүс эзэлж байна (Зураг 4.2.2, Хавсралт хүснэгт 4.1.4-4.1.9). Энэ нь ажлын байранд мэргэжил эзэмшсэн хүнийг авах хандлага нэмэгдсэнтэй холбоотойгоор суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүсийн хувьд ажилгүйдэл өртөх магадлал өндөр болсныг харуулж байна.

Судалгаанаас үзэхэд 2010 онд дээд боловсролтой боловч ажилгүй хүн амын тоо нэмэгдсний дотор доктор, магистрын зэрэгтэй хүмүүсийн тоо ч өсчээ. Энэ нь манай улсад их, дээд сургууль, коллежийн тоо олширсон, тэдгээрт элсүүлэх мэргэжлийн чиглэл, хэрэгцээ, тоо хэмжээг оновчтой төлөвлөн тогтоодоггүй, мөн дээд боловсролын чанар, үнэлээмж доогуур байгаатай холбоотой юм (Зураг 4.2.2).


**ЗУРАГ 4.2.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН**




Ажил эрхэлдэггүй хүн амыг хүйсээр нь авч үзвэл 2010 оныг 2000 онтой харьцуулахад суурь боловсролтой эрэгтэй, эмэгтэй хүн амын хувийн жин буурсан боловч, эрэгтэйнх эмэгтэйгээс илүү хэвээр байна. Харин 2010 онд дээд боловсролтой ажил эрхэлдэггүй хүн амын тоо үлэмж өссөний дотор эмэгтэйчүүдийнх эрэгтэйгээс 4.1 хувиар илүү байна (Зураг 4.2.3).

Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй боловсролгүй хүн амын бичиг үсгийн мэдлэгийг хүйсээр нь ангилж үзэхэд 2010 онд 2000 оныхаас бичиг үсэг мэддэг эрэгтэй хүн амын тоо 5.5 хувь, эмэгтэйнх 2.7 хувиар тус тус буурсан байна.

#### ЗУРАГ 4.2.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН



**ЗУРАГ 4.2.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГГҮЙ БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН**



Арван тав, түүнээс дээш насны ажилгүйчүүдийн боловсролын төвшинг аймаг, нийслэлээр ангилж үзэхэд тусгай мэргэжлийн дунд, техникийн болон мэргэжлийн дунд, бүрэн дунд боловсролын хувьд бүх аймаг, хотын эзлэх хувийн жин ойролцоо байна. Харин бага болон суурь боловсролтой ажилгүй хүн амын хувьд Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймагт бусад аймгаас бага байна. Дээд боловсролтой ажилгүй хүн амын хувийн жин Улаанбаатар хот (25.0%), Орхон (21.6%), Дархан-Уул (18.5%) аймагт бусад аймгаас илүү, харин Өвөрхангай (8.8%), Дундговь (9.0%), Дорнод (9.6%) аймагт бусад аймгаас бага байгаа нь ажиглагдлаа (Хүснэгт 4.2.1).

Арван тав, түүнээс дээш насны ажилгүйчүүдийн боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгийг байршилаар нь авч үзэхэд дээд боловсролтой хүний хувийн жин Улаанбаатар хот (25.0%), Орхон (21.6%), Дархан уул аймаг (18.4%), Баян-Өлгий (16.4%)-д өндөр байхад Дундговь аймаг (9.0%), Дорнод аймаг (9.6 %)-т бага байна. Бүрэн дунд боловсролтой ажилгүйчүүдийн хувийн жин бүх аймаг, хотод өндөр буюу 30.5-49.4 хувь байна. Боловсролгүй ажилгүйчүүдийн тоо Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Дорнод, Ховд аймагт харьцангуй их байхад Улаанбаатар хот, Дархан-Уул, Өвөрхангай, Орхон аймагт бага байна (Хүснэгт 4.2.1).


**ХҮСНЭГТ 4.2.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН  
БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН**

Аймаг, нийслэл	Боловсролтой						
	Дээд боловсрол	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн дунд	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловс- ролгүй
<b>БҮГД</b>	<b>17.3</b>	<b>4.8</b>	<b>4.3</b>	<b>42.4</b>	<b>20.3</b>	<b>7.6</b>	<b>3.3</b>
Архангай	11.4	3.6	3.8	41.4	21.5	12.9	5.4
Баян-Өлгий	16.4	6.5	6.5	30.6	18.6	15.5	5.9
Баянхонгор	10.8	2.5	5.1	37.3	28.2	11.3	4.7
Булган	11.5	4.1	5.0	43.5	26.1	7.8	2.0
Говь-Алтай	12.5	4.6	6.9	35.0	25.9	11.3	3.8
Дорнговь	13.5	5.1	5.1	38.2	27.7	6.8	3.5
Дорнот	9.6	3.9	5.7	37.8	28.4	8.5	6.0
Дундговь	9.0	4.5	6.3	25.7	31.2	15.1	8.3
Завхан	13.0	3.9	4.5	39.5	23.5	11.1	4.4
Өвөрхөнгай	8.8	3.0	3.6	33.0	26.4	17.1	8.2
Өмнөговь	12.5	3.6	5.5	34.5	28.9	10.3	4.6
Сүхбаатар	11.5	3.5	6.4	32.2	27.5	11.1	7.9
Сэлэнгэ	11.6	4.3	5.7	45.7	24.7	5.9	2.0
Төв	10.8	3.8	6.6	37.8	28.8	8.7	3.4
Увс	13.9	4.6	6.2	30.5	26.4	11.5	6.8
Ховд	15.1	4.5	4.2	39.2	20.5	10.6	6.0
Хөвсгөл	11.3	3.3	4.3	38.7	24.0	13.9	4.5
Хэнтий	11.2	2.8	6.0	33.8	31.8	9.6	4.8
Дархан-Уул	18.5	5.8	5.2	48.2	17.0	3.8	1.4
Улаанбаатар	25.0	6.0	2.8	49.4	12.8	2.9	1.0
Орхон	21.6	4.1	3.9	48.3	16.7	4.1	1.4
Говьсүмбэр	11.9	5.0	2.5	43.4	24.9	8.1	4.3

### **4.3. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРТ АЖИЛЛАДАГ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ**

Ажил эрхэлдэг хүн амыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр ангилж үзэхэд 2000 онд ажил эрхэлдэг хүн амын 47.1 хувь нь ХАА, ан агууур, ойн аж ахуйд 8.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварын салбарт, 7.6 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалд, 7.2 хувь нь боловсруулах үйлдвэрт, 6.6 хувь нь боловсролд, 5.4 хувь нь тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, хуурай замын тээвэрт, 3.9 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамжид, 1.7 хувь нь барилгад, үлдсэн нь бусад салбарт ажиллаж байжээ. Тэгвэл 2010 онд ХАА, ан агууур, ойн аж ахуйд 26.4 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин засварт 12.8 хувь, боловсролд 8.7 хувь, төрийн удирдлага, батлан хамгаалахад 8.2 хувь, боловсруулах үйлдвэрлэлд 6.9 хувь, барилгад 6.4 хувь, тээвэр агуулахын үйл ажиллагаанд 5.8 хувь, уул, уурхай олборлолтод 5.3 хувь, эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаанд 3.9 хувь, үлдсэн нь бусад салбарт тус тус ажиллаж байна.

**ЗУРАГ 4.3.1. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХУВИАР, 2000, 2010 ОН**



2010 оныг 2000 онтой харьцуулахад ХАА, ан агнуур, ойн аж ахуйд ажиллагчдын хувийн жин 26.0 хувиар буурсан, харин бөөний болон жижиглэн худалдаа, машин засварынх 4 хувь, барилгынх 4.7 хувиар тус тус өсчээ.

2000 онд ажил эрхэлдэг хүн амын 4 хувь нь боловсролгүй, үүний дотор 62.0 хувь нь бичиг үсэг мэддэг, 38.0 хувь нь бичиг үсэг мэддэггүй байсан бол 2010 онд ажиллагчдын 3.5 хувь нь боловсролгүй, үүний дотор 68.0 хувь нь бичиг үсэг мэддэг, 32.0 хувь нь бичиг үсэг мэддэггүй байна (Хавсралт хүснэгт 4.3.1).

Ажил эрхэлдэг хүн амыг эдийн засгийн үйл ажиллагааны тухайн салбар, боловсролын төвшингээр нь ангилж үзэхэд 2010 онд ХАА, ан агнуур, ойн аж ахуйд ажиллагчдын дөнгөж 2.2 хувь нь дээд, 2.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.9 хувь нь техник мэргэжлийн дунд боловсролтой байхад 23.7 хувь нь бүрэн дунд, 37.6 хувь нь суурь, 29.7 хувь нь бага боловсролтой, 12.7 хувь нь боловсролгүй байна.

Боловсруулах үйлдвэрлэлд ажиллагсдын 25.3 хувь нь дээд, 45.6 хувь нь бүрэн дунд, 13.2 хувь нь суурь боловсролтой байхад барилгад 23.5 хувь нь дээд, 43 хувь нь бүрэн дунд, 16.8 хувь нь суурь боловсролтой байна.

Бөөний болон жижиглэн худалдаа, машин засварт 32 хувь нь дээд, 43.2 хувь нь бүрэн дунд, 9.4 хувь нь суурь боловсролтой бол тээвэр ба агуулахын үйл ажиллагааны 20 хувь нь дээд, 49.3 хувь нь бүрэн дунд боловсролтой ажээ.

Төрийн удирдлага ба батлан хамгаалахад 52.4 хувь дээд, 25.5 хувь бүрэн дунд, 6.7 хувь нь суурь боловсролтой, боловсролд 63.4 хувь нь дээд, 17.2 хувь нь бүрэн дунд, 5.8 хувь нь суурь боловсролтой байна.

Эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаанд 44.2 хувь нь дээд, 26.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 19.1 хувь нь бүрэн дунд, 6 хувь нь суурь боловсролтой байна (Хүснэгт 4.3.1).



Ийнхүү судалгааны дүнгээс үзэхэд боловсрол, төрийн удирдлага ба батлан хамгаалах, эрүүл мэнд болон нийгмийн үйл ажиллагаанд ажил эрхэлдэг хүн амын дотор дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь бусдаас илүү (44.2-63.4 хувь) байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарт ажиллагчдын дотор бүрэн дунд боловсролтой хүн амын тоо харьцангуй өндөр буюу 17.2-49.3 хувийг эзэлж байна. Гэтэл хөдөө аж ахуй, ойн аж ахуйд ажиллагчдын дотор дээд боловсролтой хүн ам хамгийн цөөн, харин суурь /бүрэн бус дунд/ болон бага боловсролтой хүн ам харьцангуй өндөр буюу 26.4-33.4 хувийг, мөн боловсролгүй хүн ам 11.2 хувийг эзэлж байгаа нь нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн дийлэнх нь мэргэжилгүй хүмүүс болохыг илэрхийлж байна.

